# www.e-pada.com

# Тvvвэр зохиол

**Бэгзийн Явуухулан**

**Түүвэр зохиол**

Яруу найрагчийн амьд хөшөөг босгох сайхан боломж олгосон Монголын Зохиолчдын Эвлэлийн хороонд талархаж байгаагаа илэрхийлье. Мөн хэвлэлд бэлдэх явцад бүх талаар тусалсан яруу найрагчийн уран бүтээлийн нөхөд болон шавь нарт нь баярласнаа бас илэрхийлье. Энэ ботийг хэвлэлд бэлтгэхдээ, удаа дараагийн ном түүвэр, тогтмол хэвлэлүүдэд хэвлэгдсэн шүлэг зохиолоос гадна гар бичмэлээр үлдсэн шүлэг зохиолуудаас нь сонгож эмхтгэлээ. “ Түүвэр зохиол “ – д бүрэн гүйцэд төгсөөгүй, дутуу үлдсэн хэдэн шүлэг зохиол орсон. Яруу найрагч, шүлэг зохиолоо түргэн түүхий хийдэггүй, эргэж няхуур ажилладаг байсан тул дутуу үлдсэн зохиол нэлээд байна. Үүнээс гадна, хэвлэлд бэлтгэгч бидний дадлага туршлага багатайгаас шалтгаалж хэвлэлд бэлтгэн оруулж чадаагүй шүлэг нэлээд үлдлээ. Шүлэг зохиолуудыг эмхтгэхдээ редакторын зөвлөсний дагуу улс төр иргэний уянгын яруу найраг, утга уянгын яруу найраг гэсэн хоёр хэсэгт ангилж, хэд хэдэн дэд сэдэвт ерөнхийлөн хуваагаад, дотор нь оны дэс дараагаар байрлуулахыг эрмэлзлээ. Дууль, найраглал зэргийг сэдэв харгалзалгүй нэгэн хэсэг болгож оны дэсээр байрлууллаа. Яруу найрагч маань сэрүүн ахуй цагтаа үргэлж хүндэтгэж явсан уншигч нарт нь уран зохиолын тухай өгүүлэл, уран сайхны найруулал, тэмдэглэл, жүжиг, орчуулга зэрэг бүтээлүүдээр дахин нэг боть ном бэлтгэж толилуулах эрмэлзэл дүүрэн байгаа гэдгээ хэлэхийг хүсч байна.

Эмхтгэгчид

**Алаг дэлхийд төрсөн минь учиртай**

Алтан дэлхийд төрсөн минь учиртай
Аавын гэрийн амар тайвныг эвдээд би
Ачит эхээ арван сар зовоосны эцэст
Алаг үр нь болж баярлуулах гэсэн юм би
Алтан дэлхийд төрсөн минь учиртай

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Гэрэлт орчлонд төрсөн минь учиртай
Гэмгүй шувуудын үүрийг эвдэж өндгий нь няцлаад
Хэрсүү сууж ухаан орсныхоо эцэст
Гэнэн насаа өрөвдөж зовж явах гэсэн юм би
Гэрэлт орчлонд төрсөн минь учиртай

Алаг дэлхийд төрсөн минь учиртай
Адуу манаж дассан атархан тал нутагтаа
Анхны дурлалтай учирч эмнэг сэтгэлээ уяраагаад
Аз дутаж амьдралын турш мөрөөдөх гэсэн юм би
Алаг дэлхийд төрсөн минь учиртай

Тоост хорвоод төрсөн минь учиртай
Тохойн чинээхэн үрийнхээ шөнийн уйлахыг сонсож
Төрсөн эцгийндээ авчирсан зовлон баяр хоёрыг
Тоо ёсоор нь өөрөө амсаж мэдэх гэсэн юм би
Тоост хорвоод төрсөн минь учиртай

Дуулим хорвоод төрсөн минь учиртай
Дуулж суугаад ээжийгээ уйлахыг нь үзэх гэж
Дуунд тийм чадал шингэж байдгийг мэдээд
Дуу өөрөө зохиож дуутай хамт амьдрах гэсэн юм би
Дуулим хорвоод төрсөн минь учиртай

Хөрст дэлхийд төрсөн минь учиртай
Хүлгийн зоо болсон төрсөн нутагтаа амьдрах гэж
Хүүгийн сэтгэлээр эх орондоо хайртай байсан юм гэж
Хойч үеэрээ ам бардам хэлүүлэх гэсэн юм би
Хөрст дэлхийд төрсөн минь учиртай
1959 он.

## Алдарт буудлага

Арван долоон онд, манай гариг дээр
Алдар цуутай буудлага болсон юм.
Нэлэнхүй орчлонг нэлд нь доргиож
Нева мөрөн дээр нирхийсэн юм.

Хуучин, шинэ ертөнцийг зааглан
Хорвоод нүргэлсэн Аврорын буудлага
Хувьсгалжсан Оросын пролетарийн
Хоолой нийлүүлсэн уухай байсан юм.

Алдарт Октябрийн хүчит уухайг

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Аугаа Ленин биеэр удирдсан юм
Нийтээр бүрхэг Орос оронд
Нийгэм журмын үүр цайсан юм.

Хорвоод нүргэлсэн Аврорын дуунаар
Хотол Монгол нойроос сэрсэн юм.
Хонгор морио, Сүх жанжинд
Хувь заяагаа даатган эмээллэж өгсөн юм.

Хүн ардынхаа хувь заяаг
Хүлэг морьдынхоо дэлэнд өлгийдөж
Хувьсгал хийхээр журамт цэрэг гарахыг
Кремлийн ордонд Ленин мэдсэн юм.

Залуурч Лениний эх оронтой
Заяа холбосон Азийн монгол
Тив алгасах пуужин адил
Нийгэм алгасах хувьсгал хийсэн юм.

Хүчит аврорын буудлагын нүргээн
Хүчирхэг Лениний уухайн түрлэг
Үүл нүүгч манай гаригаас
Үүрийн цолмонд бяраа хүргэлээ.

Арван долоон онд манай гариг дээр
Алдар цуутай буудлага болсон юм.
Гариг алгасах алдарт буудлага
Гайхамшигт Нева дээр анх болсон юм.

1967 он.

## Хоёр их буу

Хүргэх ачаа хүнд
Хүлээсэн хугацаа богино
Жанжин Сүхэд гардуул
Заасан хугацаанд биелүүл
Дарга ингэж тушаав
Далан цэрэг давтав.

Өдөт бичиг яаралтай
Өндөр уул шиг жинтэй
Хоёр лут их бууг –
Хоёр лут хүнд ачааг

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Хос дөрвөн морь
Хоёр ачааны найман морь
Даахтай үгүйтэй хөдлөв
Далан цэрэг дагав.

Ачсан ачаа хүнд
Аваачих газар зайдуу
Тахтай морьд гэлдэрнэ.
Далан цэрэг яарна.

Умар зүгээс урагшлах бүр
Улсын хилд ойртох бүр
Замын нуруу хотолзов
Замгүй газар навталзав

Хоёр лут их бууг
Хоёр лут хүнд ачааг
Урсгал Сэлэнгээс өөр
Улсын хилд ойр
Дааж гаргах газаргүй байв.
Далан цэрэг мэдэж байв.

Хорин нэгэн он билээ.
Хаврын нэгэн өдөр билээ.
Нуруу юугаа Сэлэнгэ
Нум шиг бат хөвчлөв.

Хаврын зөөлөрсөн мөсөө
Хаш шиг хатуу болгов

Өдөт бичиг шиг яахалтай
Өндөр уул шиг жинтэй
Хоёр лут их бууг
Хоёр лут их хүнд ачааг
Далан орос цэрэгтэй нь
Далан найман морьтой нь
Нуруун дээрээ Сэлэнгэ даав.
Нутгийн хилийг алхуулав.

Хоёр их буу хөдлөв.
Ханын хөндийг өгсөв

Торойсон цагаан тоос угтав.
Тоосны үзүүрт Сүхбаатар ирэв.

Чандаган цагаан тогтож ядав.

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Жанжин Сүх ингэж хэлэв.

- Хоёр их буу эхлээд буудна
Хувьсгалын дуу түүгээр дуурсана.

Хортон дайсан чихгүй болно.
Хотол Монгол жаргалтай золгоно.
Жанжин Сүх түрүүлээд давхив.
Чандаган цагаан нь сум шиг хурдлав.

Хөллөгөө морьдын чих сортолзов.
Хөтөч цэргүүдийн хийморь сэргэв.

Эрээн нарсанд үүр цайв.
Их бууны дуу нүргэлэв.

Журамт цэрэг хиагтыг дайрав.
Жанжин Сүх магнайд нь явав.

Дөрвөн пулемёт зэрэг галлав.
Дөтийн замаар гаминг тонилгов.

Их бууны анхны нүргээнээр
Эрэлхэг Сүхбаатарын уриан дуунаар
Хуучин төрийн сүлд зайлав.
Хувьсгалт төрийн наран мандав.

Хоёр их буу хүнд байсан юм.
Хөрст газар хотолзож байсан юм.

Аврорын дуу биед нь явсан юм
Ардын маань хувьсгалын дуу болсон юм.

1969 он.

## Бүх ардын наадам

Эх орныхоо түүхт ойг улс даяар тэмдэглэх гэж
Эмээлт мориныхоо хурд чадлыг хотол даяар шалгах гэж
Өвч Монгол улсын “ Эрийн гурван “ наадам эхэллээ.
Үзэмжит хувцсаа өмсөөд хүмүүс наадамдаа ирцгээлээ.
Сайн малчны тэмдэгтэй буурал өвгөн харагдлаа.
Сангийн аж ахуйн тракторч залуу бүсгүй үзэгдлээ
Бүрэнцогтын уурхайчин хүдэр эр сууж байлаа.

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Бүтэн бум явчихсан залуухан жолооч ирсэн байлаа.
Тэсийн голын унага асрын үүдэнд хазаар дарж
Тэрхийн голын хүүхэн түүнийг ажиж суулаа.
Дархан аваргуудын цолыг засуулууд нь дуудаж
Түрүүлж хэн нь шалгарахыг наадамчид таалцаж байлаа.
Эрхийдээ ончтон энд нум сумаа агсаж
Эр биедээ бяртан тэнд зодог шуудгаа өмсөж
Дуу хуурын эхэнд залуучууд бүжиглэж байлаа.
Дугараа түрлэгийн эхэнд настнууд хүндлэгдэж байлаа.
Арвайхээрээс пионер хүү морь уралдахаар ирсэн байлаа.
Алтай нутгаас эмгэн малчин уригдаж ирсэн байлаа.
Зочидын байранд олон хүн ирсэн харагдлаа
Зөвлөлтийн төлөөлөгчид хамгийн түрүүнд нүдэнд туслаа
Ардчилсан орны төлөөлөгчид дэргэд нь сууж байлаа
Ардын наадамд баясан инээж суугаа үзэгдлээ
Нарийн торгон зодог шуудагтай хоёр бөх
Наадамчдын өмнүүр дэвэн дэвсээр гарлаа
Начин шонхор зоригтны тулахыг үзэх гэж
Нам чимээгүй болоод хүмүүс ширтэж эхэллээ
Эхлээд хоёулаа бие биесээ хэрж баахан зогслоо
Энд тэндээсээ чангаалцаж жаахан өвдөлцлөө
Гэтэл нэг нь ухасхийн дайраад орлоо
Гэнэдүүлж байгаад өвдөг дороо хийж амжлаа
Хоромхон зуур алга ташилт ч нижигнэж эхэллээ
/Хурдан морь/ирлээ гэж зар ч тараад ирлээ
Хурц туурайтай хүлэг морьд ана мана айсуй явлаа
Хамгийн түрүүнд хээр морь их наадамд цулбуур хаялаа
Урсах усны долгио шиг туг далбаагаа намируулсаар
Улсын аварга тамирчид жагсаалаараа орж ирлээ
Наадмын талбарт ЭНХ ТАЙВАН/гэдэг үсэг боллоо
Наргиан болж,олон үзэгчид алга ташлаа
Долоон сарын тэнгэрт туг далбаа намилзаж харагдлаа
Дөлгөөн сайхан агаарт энхийн тагтаа нисэж үзэгдлээ
Эссэн айргаа хүндэт зочдодоо дахин сөгнөлөө
Эрийн гурван наадам ид дундаа үргэлжилж байлаа.
1953 он.

## МАРКС /ДУУЛЛЫН ДУУЛЛЫГ БИЧИХДЭЭ /

Жуулч бөмбөрцөг аян замдаа эргэлдсээр
Зун өвлийг хорвоод бас л солилцуулсаар
Шөнө өдөргүй баячууд л цэнгэлд автана
Сарны гэрэлд боолчууд л зогсоогүй ажиллана
Бөмбөрцөг дэлхий гэдэг нь бүрэг саарал юмуу?

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Бүгд бид гаслан зовлонд төрсөн юмуу?
Ийм үгтэй дууг ажилчин хүн дуулж байхад
Үүр шөнийг угтаж Маркс нойргүй сууж байлаа
Ширээн дээрх гэрэл нь бүдэг гийгүүлнэ
Шилэн гэгээвчийг нь нэвтлэн салхи сэвэлзэнэ...
Эвхмэл цаасыг дэлгээд Маркс урдаа тавилаа
/Эв хамт намын тунхаг/гэж гарчиг бичлээ
Сайн нөхөр Энгельс нь дэргэд нь сууж байлаа
Санаа бодолоо сүвэгчлэн Маркс зөвлөж байна.
Үзгээ тавиад Маркс шинэ ертөнцийг бодоход нь
Урт цагаан сахлаа илэн байж суухад нь
-Бидний замыг зааж өг!Маркс минь гэх шиг
Бэрсүү болсон пролетариуд өөдөөс нь сарвайгаад
Найман настан эзний газар дээр ажиллаж харагдлаа
Ная хүрсэн эрдэмтэн хөлсний хөдөлмөр хийж үзэгдлээ
Бүхэл дэлхий туждаа тас харанхуй харагдлаа
Бүүр шинээр хувиргах цаг нь болсон санагдлаа
Эргүүлж болшгүй мөрөн голын урсгал шиг
Энд тэндгүй ажилчдын бослого гарч байгаа нь
Түмэн жил хээр хэвтсэн нуруу өвсөнд
Түүдгийн оч үсрээд авалцаж байх шиг бодогдлоо
Тэгвэл одоо ганцхан хувьсгалын шуурга хэрэгтэй
Түм буман пролетариудад хувьсгалын уриа хэрэгтэй
Энэ бүгдийг бодоод Маркс үзгээ барилаа
Эгэл олон пролетариудын замыг зааж бичлээ...
“ Олохдоо бид бүх дэлхийг олж авна “ гэж тунхаглалаа.
Олох шинэ хувьсгал нь орчлонгийн хэвлийд өсөж байлаа.
“ Орон бүхний пролетари нар нэгдэгтүн “ гэж уриаллаа.
Олон сая пролетариуд энэ уриан дор нэгдлээ.
Ган үзгээ Маркс ахин ахин хурдлуулахад
Капитализм дарлалаа дахин дахин ширүүсгэлээ.
Дарлагч ангийг түлхэн унагаахыг Маркс заахад нь
Дарлагдсан пролетариудын эрх чөлөөний замыг нээхэд нь
Сая сая ажилчдын хувьсгалч гарууд яралзлаа.
Шив шинэ дэлхийн амгалан дүр тодорлоо.

1953 он.

**Ленин – Москва**

Зүг зүгийн орныг
Туяа гэрлээр гийгүүлж
Зүү орохгүй эвийг
Түмэн олонд заясан

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Үнэн зөв ялалтын
Эцэг нь болсон Ленин
Үүрдийн энх тайвны
Эх нь болсон Москва
Үндэстэн олны хүүхдийн
Ариун ирээдүйг холбож
Үнэн ариун хэргийн
Алтан жигүүрийг дэлгэсэн
Үнэн зөв ялалтын
Туг нь болсон Ленин
Үүрдийн энх тайвны
Түшиг нь болсон Москва
Саруул жаргалын нараар
Гийгүүлж байдаг гүрэн
Сайн санаатан бүхнээр
Хүрээлүүлж байдаг нийслэл
Үнэн зөв ялалтын
Нар нь болсон Ленин
Үүрдийн энх тайвны
Од нь болсон Москва.

1951.он

**Москвагийн Дуун**

Хонгор минь радиогоо чангалаарай,
Кремлийн цаг уянгалж байна шүү.
Хоногшиж дассан дуугаар “ Москвагаас ярьж байна “ гэнэ дээ.
Хоёр биеэ ширтэж баясанхан сууж хоёулаа
Хосгүй сайхан Москвагийн дууг
Өвгөн буурал Кремлийн өндөр цамхаг дээгүүр
Үүлэн өнгөт тагтаан сүрэг нисэж яваа нь үзэгдэх юм.
Үргэлж баяраар гийсэн үйлдвэр завод дотроо
Өнөр Зөвлөлтийн хүмүүс ажиллаж байгаа нь харагдах юм.
Чагнав уу? Хонгор минь. Ижил- Доны сувгаар,
Маргад эрдэнийн бараатай галт онгоц хөвж явааг !
Сонсов уу? Хайрт минь. Дорнодын ган замаар
Зөвлөлтийн бэлэг наашаа гарлаа гэж байгааг !
Амьдрал үнэн хоёрыг ингэж дуулгаж байдагт нь
“ Америкийн дуу хоолой “ шиг шал худлаа чалчдаггүйд нь
Мөнх саруул Кремлийн гэрэлт од гялалзан байдаг
Москвагийн дууг сонсохдоо дуртай юм би чинь !
Хонгор минь радиогоо чангалаарай,
Кремлийн цаг уянгалж байа шүү.

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Хоногшиж дассан дуугаар “ Москвагаас ярьж байна “ гэнэ дээ
Хоёр биеэ ширтэж баясанхан сууж хоёулаа
Хосгүй сайхан Москвагийн дууг сонсьё !

1952он

Өдөржин би Улаан талбайгаар явав.
Өөрөө мэдэлгүй бүхэл өдөр эрэл хийв.
Уг нь би энд зүгээр л ирсэн юм.
Улаан талбайд очьё л гэж бодсон юм.

Харин, энд Сүхбаатарын мөр бийг,
Харах нүдэнд одоо яасан ч үзэгдэхгүйг,
Ариун гараар бүтээгүй тэр дурсгалыг
Алдарт Улаан талбай хадгалж байгааг

Сэтгэлдээ санаж, талбай дээр явахад
Сүлжмэл угалзтай монгол гутлын чимээ гарч
Сүхбаатартай өдөржин хамт байх шиг санагдав.

Үнэндээ тэр мөрийг би эрээгүй боловч
Итгэл хайрын хүчинд захирагдаж
Өдөржин би улаан талбайгаар явав.

**Лениний тухай дуу**

Хуучин төрийн туургыг халж
Шинэ нийгмийн тооныг тулж
Нийгэм журамт улсаа байгуулж
Нийт олноо тэгш жаргуулсан
Сод Ленин
Суут Ленин
Ленин –
Гэрэлт од шиг
Замд баримжаатай,
Ленин гэгээн тэнгэр шиг
Орчлонд түгээстэй.
Орос хүн шигээ эгэл төрж
Олон үндэстний хайрыг булааж
Зон олныхоо тэмцлийг манлайлж
Зовлон жаргалыг хамт туулсан
Эгэл Ленин
Их Ленин
Ленин

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Эцгийн дүр шиг
Зүрхэнд уяатай
Ленин –
Эхийн сэтгэл шиг
Бүхэнд энэрэлтэй
Суут Марксын ухааныг тэлж
Саруул коммунизмын дүрийг тодосгож
Хүн төрөлхтний заяаг тэтгэж
Хүрэх ирээдүйн замыг заасан
Зөнч Ленин
Мөнх Ленин
Ленин –
Цаст оргил шиг
Орчлонд бараатай
Ленин –
Нарт хорвоо шиг
Олонд түшигтэй.

1970 он.

## МОСКВА

Москва минь, Москва минь,
Монгол эхээс минь өөрцгүй
Эрдмийн сүүгээ шимүүлсэн
Эрхэм их ачтан минь

Москва минь, Москва минь
Монгол нутгаас минь өөрцгүй
Элэг зүрхэнд өөриймсөж
Идээшиж дассан гэр минь

Алс холын Монголын
Аз жаргалтай эзэн
Ард язгуурт хүний
Алаг үр гэлээ ч би

Сүрлэг Москва чиний
Сүү шиг хайранд багтаж
Өр зүрхэнд чинь үүрээ барьсан
Өчүүхэн хараацай билээ би.

Анх чамдаа ирж
Улаан талбай дээр гараад

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Аугаа их Ленинд
Цэцэг өргөхдөө би

Амьд явах насанд
Цээжинд дандаа байдаг
Аавын сайхан дүрийг
Олж үзсэн билээ би

Энхрий олон үрстэй
Элгэн өвөрт чинь багтаж
Эрдмийн сүүний чинь шимийг
Эгнэгт хүртэхдээ би

Энэ яваа насанд
Ачийг нь хариулж дуусашгүй
Эхийн халуун хайрыг
Олж амссан билээ би.

Идэр бүргэд шиг сүртэй
Эрчүүлийн чинь зангаас
Эр хүний гүндүүгүйг
Олж харсан билээ би

Ингэн нүдэн тормойсон
Эмэгтэйчүүдийн чинь царайнаас
Эх хүний гоо сайхныг
Олж үзсэн билээ би

Өнөр сайхан бүлийн чинь
Өөдрөг сайхан жавхаанаас
Үндэстэн олны нөхөрлөлийн
Үр шимийг харсан би.

Анд олон нөхдийн чинь
Аз заяатай холбооноос
Ах дүүгийн барилдлагын
Аугаа гайхамшигийг мэдэрсэн би

Цэнхэр нүдэн найзтайгаа
Цэлмэг тэнгэрт өндөр авч
Далай жаргалын хураар
Далавчаа дэвтээж явахдаа

Өнгөт орчлонгийн царайг
Өндөр дээрээс харж

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Үзэл санааны тэмүүллээ
Өөрийн болгож авсан би.

Москва минь чи надад
Өгөөгүй юм гэж огт байхгүй
Москва минь би чамаас
Аваагүй юм гэж огт байхгүй

Сүрлэг Москва чиний
Сүү шиг хайранд багтаж
Өр зүрхэнд чинь үүрээ зассан
Өчүүхэн хараацай билээ би.
Халуун элэгсэг зүрхэнд чинь
Холоос нисэж ирэхдээ
Хаврын анхны шувуу шиг
Мөрөөдөж ирдэг билээ би.

Найрсаг үүрээ орхиод
Нисэн одохын цагтаа
Намрын сүүлчийн шувуу шиг
Хоргодож буцдаг билээ би

Москва минь, Москва минь
Чиний алтан босго
Хань нөхдийн өмнө бол
Хавтгай газар шиг намхан билээ.

Москва минь, Москва минь
Чиний алтан босго
Харь дайсны өмнө бол
Хадан уул шиг өндөр билээ .

Өстөн шунахай дайсны
Өмхий санаанаас болж
Ард түмний гар дээр үлдсэн
Атаатантай тулах ганц зэвсэг

Зандан ташууртайгаа очсон
Залуу жанжин Сүхбаатарыг
Аугаа их Ленин
Алтан Кремльд чинь хүлээн авч

Хүндэт зочны ёсоор
Хүсэл зоригийг нь сонсож
Авророын бууны цэнэгийг
Алган дээр нь тавьж өгсөн юм.

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Аврорын домогт бууны
Атомаас хүчтэй цэнэг
Ар Монголын нутагт
Атаатны үүрэнд дэлбэрэх дээ:

Газар унасан хэсэг нь
Ган бат найрамдлын гэр болж
Өнөөдрийн социалист Монголын
Өндөр сүрлэг барилгын

Өлмий бат орших
Өлзийт суурийн чулуу болж
Монгол орон даяар
Молор эрдэнэ шиг гялалзсан юм.
Тэнгэрт хадсан чимээ нь
Тэр чигтээ эгшиглэж
Энхрий эх орныхоо
Эрх чөлөөтэй эзэн

Ард түмний дуулах дуртай
Аз жаргалын дуу болж
Өргөн уудам нутгийн минь
Өнцөг бүхэнд хангинасан юм.

Москва минь чи бидэнд
Өгөөгүй юм гэж огт байхгүй
Москва минь бид чамаас
Аваагүй юм гэж огт байхгүй

Ийм сайхан ачтантай
Эгнэгт бат нөхөрлүүлсэн
Аххмад үеэрээ бахархана
Ачит намдаа баярлана.

Хөх мөнх тэнгэрийн
Нэрийг барин хэлье
Монгол хүний үр би
Москва чамдаа хайртай

Хөрст хатуу газрын
Нэрийг барин хэлье
Монгол хүн бүгдээрээ
Москва чамдаа хайртай

Мөнх хөх тэнгэрийн дор

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Москва чамайг байгаа цагт
Өнгөт дэлхий тэнхлэгээ
Өнө мөнх эргэнэ.

Газар дэлхийн хөрсөн дээр
Гайхамшигт Москва байгаа цагт
Ах дүүгийн барилдлага ялж
Ард түмэн бүгдээрээ жаргана.

Москва- Улаанбаатар
1981 он

## МОСКВАГИЙН УЛААН ТАЛБАЙ

Элгэн хатуу боржин чулууг
Энэ дэлхийн пролетари нарын
Эв санааны нэгдэл шиг
Эвтэйхэн зүйж дэвссэн
Ямар бат бэх талбай вэ?
Москвагийн улаан талбай.

Арван сая Москвагийнхан
Аз жаргалын жагсаалд жигдрэхдээ
Эх орныхоо бүх хүн ам,
Энэ дэлхийхэнтэй хамт багтдаг
Ямар уудам талбай вэ?
Москвагийн улаан талбай.

Дээр нь байгаа Лениний дүр
Дэлхийн нар шиг гэрэлтэж
Дэлгэр их энгээ дэлгээд
Дэрвэж байгаа туг шиг
Ямар хүндэтгэлтэй талбай вэ?
Москвагийн улаан талбай.

1981 он
Москва

## САЙН БАЙНА УУ, УЛААНБААТАР МИНЬ

Хүүгээ өлгийдөөд орхисон эх шиг
Хүний нутагт сэтгэл тогтсонгүй

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Холоос гүйсэн хангал морь шиг
Хорвоод хосгүй чамдаа ирлээ.
Сайн байна уу, Улаанбаатар минь?

Хүний сайхан үрийг үзээд
Өөрийн үрийг хэн мартах вэ
Бороонь дараах нар шиг чамайгаа
Бэтгэртлээ би чинь санаж явлаа.
Сайн байна уу, Улаанбаатар минь?

Саяхан мэндэлсэн эх үр хоёр
Сайхан хүйгээрээ холбоотойн адил
Энхрий хот чамтайгаа би
Энэ биеэрээ хлбоотой юм.
Сайн байна уу, Улаанбаатар минь?

Тив дэлхийн уудам гэдэг
Тэнүүн болоод уужим юм.
Тохмын чинээ зайгий нь эзлэх
Төрөлх нутаг үнэтэй юм
Сайн байна уу, Улаанбаатар минь?

Хүүгээ өлгийдөөд орхисон эх шиг
Хүний нутагт сэтгэл тогтсонгүй
Холоос гүйсэн хангал морь шиг
Хорвоод хосгүй чамдаа ирлээ.
Сайн байна уу, Улаанбаатар минь?

1959 он.

## УЛААНБААТАРЫН УЯНГЫН ДУУ

Алгаар хааж болдоггүй
Алтан жаргал нарны дор
Азаар заясан хорвоогийн
Арван найман насандаа
Хаяад явчихаж болдоггүй
Хархан нүдний талимаанд
Харих цагаас хождоод
Хан ууланд оройтоход минь
Буурал ээжийтэй минь хамт
Буцаж ирэхийг минь хүлээж
Уудам Азийн Монгол –
Улаанбаатар нийслэл минь

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Дөрвөн уулын дундаа
Тэнгэрийн заадас шиг ярайна.

Үгээр хуурч болдоггүй
Эх орныхоо ивгээл дор
Үзэж өнгөрүүлэх амьдралын
Үд дундын насандаа
Хуудуу хийчихэж болдоггүй
Хэцүү ажлын эрхээр
Хоног хугацаа хождоод
Холын замд оройтоход минь
Энхрий янагтай минь хамт
Эргэж ирэхийг минь хүлээж
Удам Азийн Монгол –
Улаанбаатар нийслэл минь
Дөрвөн уулын дундаа
Тэнрэгийн заадас шиг ярайна.

Эвээр аргалж болдоггүй
Эргэх хорвоогийн жамаар
Эцгийн голомтыг залгах
Эрийн цээний насандаа
Орхиод явчихаж болдоггүй
Очтой нүдний талимаанд
Эжий аавын балчирхан
Энхрий хүүг минь оройтоход нь
Хөгшин бид хоёртой хамт
Хүүгийн минь ирэхийг хүлээж
Удам Азийн Монгол –
Улаанбаатар нийслэл минь
Дөрвөн уулын дундаа
Тэнгэрийн заадас шиг ярайна.

1967 он

## УЛААНБААТАР

Улаанбаатар – гараар амилсан Азийн цагаан тагтаа
Уран тоосгоор шүлэглэсэн хүслийн сүлд дуулал
Үүр хаярах дорнын цайлган цагаан сэтгэл
үүдээ зочиндоо дэлгэсэн танан цагаан буудал

Туулын эрэгт ургасан болрын мянган талст
Уулын дунд буусан тэнгэрийн мөнгөн заадас

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Өргөө хийдийн ормон дээр дэлгэрсэн цагаан сарнай
Өргөн Азийн элгэн дээр хаягаа тэлсэн нийслэл.

Манж, Хятадын хаадын үе дамжсан санаархал
Манай жинхэнэ андуудын ах дүүгийн бахархал
Аугаа дээдэс минь бидэндээ амиараа хадгалсан нутаг
Алтан гургалдай шиг үрс минь дуулан жаргасан цэцэрлэг

Умрын салхинд намирсан улаан тугийн дэрвээ
Урагшлах замаа сонгосон монгол түмний минь өлгий
Сансрын анхны нисгэгчээ цэцэш барьж угтах дэвжээ
Сая сая удмыг минь эх барьж авах эжий

Аав ээжийн голомтоос тулгалж дэвжээсэн гал
Ардын хувьсгалын тугийг Азид анх өргөсөн гар
Морин дэл дээр мөнхөрсөн Сүхбаатарын давхих талбай
Монгол орны минь ирээдүйг нар өөд хөтөлсөн харгуй

Урагш тэмүүлэх жагсаалын маань эхэнд барьсан тунхаг
Удам дэлхийд цуурайлсан Монголын дуу хоолой
Маркс, Лениний үзлийн Азийн бат бэх цамхаг
Мандаж бадарсан социализмын харуулын нэгэн мэлмий.

Туулын эрэгт ургасан болрын мянган талст
Улын дунд ярайсан тэнгэрийн сөнгөн заадас
Туурга тусгаар орны минь ариун гэгээн голомт
Тулганд ассан гал шиг бадрах заяаны минь үндэс.

Үүр хаяарах дорнын цайлган цагаан сэтгэл
Үүдээ зочиндоо дэлгэсэн танан цагаан буудал
Ажилсаг түмний минь зүтгэлээс дэлгэрсэн цагаан сарнай
Ариун энхийн нарны дор хаягаа тэлсэн нийслэл

Эрдэнэт гараар амилсан Азийн цагаан тагтаа
Эрх чөлөөт Монголын тусгаар тогтнолын бамбар
Дэвшилт түмний нийслэлийн тэнгэр газрын холбоо
Дэлхийн сайхан хот – миний хайрт Улаанбаатар.

1978 он.

## Сүхбаатарын талбай

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Улс монголын минь ерөнхий хот
Улаанбаатар нийслэлийн минь төвд
Сүх жанжны минь нэрээр алдаршсан
Сүрлэг сайхан талбай бий.

Энэ талбайн эргэн тойронд
Эх орон минь цэлийж байдаг юм.
Энэ талбайнхаа эргэн тойронд
Эгэл бид нар амьдарч байдаг юм.
. . . . . . . . . . . .

1982 он.

## АРАНЖИН ЭРДЭНЭТ

Цэлмэг тэнгэрийн сувдан оддыг түүгээд
Цэцэг болгож газарт шагласан юм шиг
Аранзал гэрэл нь яралзан яралзан туяараад
Аранжин Эрдэнэт минь яасан сайхан вэ?
Аранжин Эрдэнэт минь, сайхан хот минь
Аранзал гэрлээ улам улам туяаруул
Уулл нүүлгэж арвин эрдэнэ савласан
Уурхайч олноо баясган баясган туяаруул.
Үлгэрт гардаг тэнгэрийн баганыг авчраад
Үнэн болгож эгнүүлж тулсан юм шиг
Аварга яндан хүжлэн хүжлэн сүндэрлээд
Аранжин Эрдэнэт минь яасан сайхан бэ?
Аранжин эрдэнэт минь, сайхан хот минь
Аварга үйлдвэрээ улам улам сүндэрлүүл
Уул нүүлгэж арвин эрдэнэ савласан
Уурхайч олноо баясган баясган сүндэрлүүл
Хайрын захидлын сайхан бадгийг шилээд
Ханьдаа зориулж уулын дунд сийлсэн юм шиг
Андын дуугаар амилан амилан уянгалаад
Аранжин Эрдэнэт минь яасан сайхан бэ?
Аранжин Эрдэнэт минь, сайхан хот минь
Андын дууллаа улам улам уянгалуул
Уул нүүлгэж арвин эрдэнэ савласан
Уурхайч олноо баясган баясган уянгалуул.

1977-1978 он.

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

## БАГА НУУРЫН ТУХАЙ БОДОЛ

Бага нуур -
Зөвхөн нуурын ч нэр биш
Бага нуур
Зөвхөн газрын ч нэр биш.

Бага нуур –
Хар алтны их уурхайн нэр
Бага нуур
Хорвоод төрсөн шинэ хотын нэр

Хот төрөхдөө
Хүнтэй адилхан хүндтэй төрөх юм.
Хот босохдоо
Хүнтэй адилхан нэртэй болох юм.

Бага нуур минь
Хорвоод чи ингэж төрлөө.
Бага нуур минь
Хорвоод төрөхийг чинь би үзлээ.

Бага нуур –
Лут хөдөлмөрийн их дүр
Бага нуур –
Бат найрамдлын лут сүр.

Хот өсөхдөө
Хүнтэй адилхан өсөж томроно
Хот хөгжихдөө
Хүнтэй адилхан нэрд гарна.

Сүр бараа чинь
Газар дээр улам их гэрэлтэнэ.
Дүр царай чинь
Гайхам сайхан болж туяарна.

Бага нуур минь
Эргэж чамдаа заавал ирнэ.
Бага нуур минь
Идэр сайхан насыг чинь би үзнэ.

Бага нуур –
Их баялгийн минь даруухан нэр
Бага нуур –
Үр удмын минь өсөх хотын нэр

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Төрөлх хотоо
Тэд улам сайхан болгоно.
Төрүүлсэн эх шигээ
Тэд хорвоод чамайг хайрлана.

Талын дундах
Хар нүдэн нуурын нэртэй
Талын дээрх
Хаш цагаан хот минь

Хот харин
Хүнтэй адилхан өтлөхгүй
Хорвоо дээр
Өтлөх насыг чинь би үзэхгүй .

1978 он
Багануур

**ИТГЭЛ**

Хөвч тайгын мод дуулим тагаасаа гандаж
Хонгор намрын өдрүүд тал нутагт ирлээ
Хөндий дүүрэн тариагаа улсын аж ахуй хурааж
Ханагар талд аварга комбайнууд сэллээ.
Халиуран нүүгэлтэгч тариан талбарын дээгүүр
Халуун орон руу нүүдлийн шувууд зэл татлаа.
Хүчит кобайны жолоог эхийгээ залаад гарахад
Хонгор охин нь баяртай гэгч инээмсэглэлээ.
Арвин талын тариаланг тэртээ талаас нь хураасаар
Аварга комбайнууд эгнээ зэрэгцсээр ирлээ
Амраг охин нь эхийгээ тосон гүйж очоод
Аварга комбайны гинжийг зөөлөн гэгч иллээ...
Манай аж ахуй дээр энэ явдал болсон юм
Магадлаж дамжуулах нь миний үүрэг гэж бодсон юм.

Магтаал шүлэгтээ би нэмж бас хэлэхэд
Монгол хүний итгэл Зөвлөлт улсад ханджээ.

1953 он.

**ААВЫН ГАР**

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Уул шиг барьцтай аавынхаа бяртай гарт нь хөтлөгдөн
Унаган хот Улиастайнхаа баян зээлий нь сонирхон
Аавыгаа ганц алхахад нь гурав гишгэн гүйцэж
Авч өгсөн дэвтэрт нь баяртай явсанаа санаж байна.

Эрээн мяраанаа дэлгэсэн зах зээлийн газар
Энд тэндээс цугларсан хүн олны дунд
Цаст уулын бүргэдэрхүү хоёр сайхан орос эр
Цав цагаан толгойтой хоёр мундаг “ доктор “

Улс амьтны чөлөөнд дуу алдан уулзсан юм.
Учир утга нь мэдэгдэхгүй дуржигнасан хэлээр
ярьсан юм.
Аавынхаа гараас чангаасхийж ойртон очиж зогссон юм
Анд хоёрын яриаг би ойлгон мэдэх гэж ядсан юм.
Зах зээлийн хөлд төөрөгдөхөөс намайг хамгаалсан
Залуу зандан эцгийнхээ өлзийт гарт хөтлөгдөн
- Хэлээ тэд яагаад ойлгож байгаа юм бэ? гэж
Хэрэг бологж ааваасаа зам зуур шалгаасан юм.

Ой тойнд оромгүй тэр хэлнийхээ нууцыг
Орос хүн өөрөө хожим над тайлсан юм.
Одоо харин намайг хүний нутагт явахад
Оросын гайхамшигт хэл аавын гарыг орлосон юм.
1959 он.

## Лениний уулан дээр

Одоо би Лениний уулан дээр гараад
Оволзсон зүрхээ дарж ядан зогсож байна
Орчлонгийн зүрх – Москвад үүр цайж
Оргилсон хөл хөгжөөн нь эхлэх дөхөж байна.

Өндөр барилгууд нь тэнгэр баганадах шиг
Үүрийн бүрийгээс цайран тодорч байна
Өвч шөнөдөө харуулд зогссон юм шиг
Үйлдвэрийн яндангууд сэрийн үзэгдэж байна.

Тээр дороос оюутнууд дуу аялан
Тэвхийсэн номоо сугавчилсаар айсуй байна.
Тэнд Москва гол мөнгөн саа шиг гялалзан
Тээврийн хөлөг онгоцууд аялалд гарч байна.

Саяхан хүртэл гялалзаж байсан тэнгэрийн од

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Шинэ өдрийн туяанд бүүдийгээд харагдахгүй байна.

Бүх дэлхийд цуутайгаа илчилсэн шиг
Буурал Кремлийн одууд л гялалзсаар байна.

Танил дорноос цайвар туяагаа тэлсээр
Тэнгэрийн хаяанаас нар өндийж байна
Тэмүүлсэн их зорилгод минь амжилт хүсэх шиг
Туяан гэрлээ надад тусгаж байна.

1954 он
Москва

## ШУГАМ

Орлого зарлагыг
Заагладаг
Шугамыг энд яриагүй
Олон түмнээ
Жолооддог
Намаа би магтаж байна.
Хоёр цэгийн
Хоорондох
Шугам л шулуун гэж
Хэлэх юм бол
Хайрт намынхаа
Жанжин шугамыг

түүнээс шулуун гэж
хэлнэ би
Ная гарсан
Эмгэнээс
Намаа ерөөж суухыг
Дуулдаг би
Найм хүрээгүй
Хүүхдээс
Намаа нэрлэж байхыг
сонсдог би
Нар болсон
Намтайгаа
Зүрх минь хүчтэй
Цохилдог юм.
Намынхаа хэргийн
Төлөө л

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Манай хүүхдүүд
төрдөг юм.

1952 он.

**НАМДАА ӨРГӨХ ҮГ**

Морин дэл дээгүүр анх хийссэн
Монгол оронд үүрд намирсан,
Чин зоригт Сүхбаатарын
Чилэхийг мэдэхгүй гарт анх мандсан
Гал улаан тугуудын тухай
Галтай нэг бодол бидэнд төрдөг.
Тэр бол – нам
Биднийгээ жолоодож байна
Тэгээд бас намдаа
Бид үнэнчээ шалгуулж байна
Нас биеэ бид намдаа зориулаастай
Нандин хүсэл маань ирээдүйд тэмүүлээстэй
Уурхайн гүн, үйлдвэрийн цехэд
Уралдаант ажил норм давж,
Улын хормой талын арвинд
Баян сүрэг улам өсөхөд
Бүтээн босгогч бидний сэтгэлээс
Бас л тэр бодол ердөө гардаггүй .
Тэр бол – нам
Биднийгээ хөдөлмөрт зоригжуулж байна.
Тэгээд бас намдаа
Бид хүчин зүтгэлээ өгч байна.
Нас биеэ бид намдаа зориулаастай
Нандин хүсэл маань ирээдүйд тэмүүлээстэй.
Зөвлөлтийн өнөөдөр маргааш маань болж
Зүтгэл хөдөлмөрөөр эх орон цэцэглэхэд,
Зүгээр суулгүй хөдөлмөрт шамдсанаас
Чөлөөт амьдрал маань улам дэгжихэд
Нас биеэ зориулсан биднээс
Нөгөө нэг бодол бас л салдагггүй.
Тэр бол - нам
Биднийхээ амьдралыг ивээж байна.
Тэгээд бас намдаа
Бид бүхэн үгээ хэлж байна.
Нас биеэ бид намдаа зориулаастай
Нандин хүсэл маань ирээдүйд тэмүүлээстэй
Өтгөн хар үсэнд буурал суувч

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Өсөх үе маань эхээс төрдөг,
Өнөөдөр маань үдшээр дуусавч
Өрнөх маргааш өглөөгөөр эхэлдэг.
Ирээдүйдээ итгэн урагшлах тутам
Ихэр болсон тэр бодол хамт явдаг.
Тэр бол - нам
Биднийгээ ирээдүйд зоригжуулж байна.
Тэгээд бас намдаа
Бид мүхэн итгэж байна.
Нас биеэ бид намдаа зориулаастай
Нандин хүсэл маань ирээдүйд тэмүүлээстэй.

1954он

**НАМ**

Нам –
Ард олныхоо өлмийд
Алтан хивс дэвсэгч
Ажилчин.

Нам –
Эцэг өвгөдийн нутагт
Эрдэнийн сувд өсгөгч
Малчин.

Нам –
Эрдэм соёлын танхимд
Эвийн үсэг хэлхэгч
Сэхээтэн.

Нас юугаа хувьсгалаар эхэлсэн
Намтар юугаа ялалтаар зузаалсан
Манай энхрий хайрт нам
Монгол Ардын Хувьсгалт Нам

Оюун ухааны лут нэгдэл
Олон түмний бат итгэл
Яруу алдрын сод манлай
Ямагт бидний сүлд магнай

Удаан жилээр талхиж ядраасан
Ужиг нийгмийн дарлал зовлонг
Малчин ардын бөгтөр нуруунаас

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Манай нам ховхолж хаясан юм.

Бор гэрийг өргөө болгож
Богдын оронд ардыг өргөмжилж
Хуучирсан хүрээг хот болгож
Хувьсгалын тугийг оройд нь залсан юм.

Малчны дундаас ажилчин төрүүлж
Мандсан төрийнхөө жолоог бариулж
Ариун цагаан хөдөлмөрийн шимээр
Айл бүрийнхээ галыг мялаасан юм.

Анд Зөвлөлтийн баатар түмэнтэй
Ахан дүүгийн барилдлага холбож
Хань болсон итгэлт нөхдөө
Хамтын тэмцлийн замаас олсон юм.

Нэгийгээ орхихгүй халуун нэгдэлтэй
Нийтээрээ урагшлах ариун зорилготой
Бидний ирээдүй – Гэгээн Коммунизм
Бэрхшээлийг ялж хүрэх диваажин

Нас юугаа хувьсгалаар эхэлсэн
Намтар юугаа ялалтаар зузаалсан
Манай энхрий хайрт нам
Монгол Ардын Хувьсгалт Нам

Оюун ухааны лут нэгдэл
Олон түмний бат итгэл
Яруу алдрын сод манлай
Ямагт бидний сүлд магнай

Нам –
Эгэл түмнийхээ уаргалыг
Эзэрхэг дайснаас аварсан
Хувьсгалч.

Нам –
Эрх чөлөөний нарыг
Эмээл дээрээ дүүрч авчирсан
Морьтон.
Нам –
Эх орныхоо эзэн болсон
Эрэлхэг баатар ардын
Нам.

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

1981.2.27.

## Эвлэлийн алдар

Мянга есөн зуун хорин нэгэн онд билээ
Манай эвлэлийн туг түүхэнд анх мандсан билээ.
Ачит Сүхбаатар тэр тугийг өргөсөн билээ
Ардын залуучуудыг нэгтгэсэн эвлэл ингэж
байгуулагдаж билээ.
Гал улаан тугаа ингэж анх мандуулаад
Хатуужиж ирсэн алдарт ойгоо тэмдэглэж,
Тэргүүн болсон намдаа өнөөдөр бид илтгэх
Төгс сайхан амжилтыг гучин жилдээ бүтээлээ.
Цогтой үеийг нэгтгэсэн эвлэл маань хэзээ ч
Жолоодогч ах намынхаа заасан замаас гажаагүй юм.
Төр улсаа хөгжүүлэх баатар гавъат үйлсийн
Тэргүүнд явах үүргээ нэр төртэй биелүүлсэн юм.
Атаат дайсны сумыг цээжээрээ тагласан баатаруудыг,
Амлаж авсан үүргээ мянгаар давуулсан ажилчдыг,
Өнөр баян сүргээ өсгөж олшруулсан малчдыг,
Өргөн уудам ертөнцийн нууцыг тайлсан эрдэмтдийг
Манай эвлэл хүмүүжүүлж бүтээлийн эзэд болгосноос
Мандах нарны гэрэлтэй эвлэл гэж нэрлэгддэг юм.
Манлай хайрт намдаа үнэнч тусалж ирсний
Магадтай баримт болсон баатар гавъяа нь юм.
Эх орноо хөгжүүлэх таван жилийн төлөвлөгөөнд
Дадаж сурсан заншлаараа манай эвлэл түрүүлээстэй
Эгэл олны нэгдсэн энх тайвны хамгаалалд
Тэргүүнд яваа залуустайманай эвлэл зэрэгцээстэй

1951 он.

## ХОЁР ДАЛБАА

Эцэг эхийн ууган хоёр хүү шиг
Ихэр хоёр хүдэр эр хөтлөлцөж явах шиг
Алх хадуурт далбааны дэргэд
Алтан соёмбот далбаа намирч байна.

Дэрвэхэд нь чөлөөтэй байлгая гэсэн шиг
Дээгүүр нь хөх тэнгэр асарлан цэлийж байна.

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Намируулан байх гэж ертөнцөд гарсан юм шиг
Намуухан салхи илбэн таалан байна.

Хийсэж байхыг нь үзэхийн төлөө төрсөн юм шиг
Хүмүүсийн хараа далбаадын зүг тэмүүлж байна.
Он онд гийгүүлж байя гэсэн шиг
Орчлонгийн нар хүртэл гэрлээ нэмж байна.

1953 он.

## НАЙРАМДАЛ – ДРУЖБА

Дотнын халуун сэтгэлээ өвөрлөөд
Догдлон хүлээсэн зочин маань ирлээ
Хойморт гэрийнхээ үүдийг сөхөөд
Хоёр гардаж мэндлэн золгоё.
Найрамдал – дружба
Дружба – найрамдал
Цэнхэр тэнгэрэн хадгаа дэлгээд
Тунгалаг наран аягаа тавиад
Хүн ардынхаа хайраар бялхааж
Хүндэт зочиндоо өргөн барья.
Найрамдал – дружба
Дружба – найрамдал
Зузаан найрамдлын ууган жишээ,
Удаан жаргалын үүдэн дэлгээ,
Ахан дүүсийн ариун холбоо,
Ард түмний хийморь золбоо
Найрамдал – дружба
Дружба – найрамдал
Ахан дүүсийн ариун холбоог
Алаг нүд шигээ хайрлаж явья
Ард түмнийхээ аз жаргалыг
Алган дээрээ нар шиг бадраая.
Найрамдал – дружба
Дружба – найрамдал

1974 он.

## ЧУЛУУН ДЭЭРХ БИЧИГ

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Зэрэгцээх уул хаданд цуурай нь хадаж
Жигдхэн хэмнэлээр алхны дуу гарч байна.
Жигтэйхэн хатуу ургаа чулуун дээр
Жирийн нэг өвгөн бичиг сийлж байна.
Хажууд нь байгаа өвгөний ач хүү
Хадан дээрх бичгийг хуруугаараа заагаад
- Энэ бичиг ямар учиртай юм бэ? гэж
Өвөг эцгээсээ шалгаан асууж байна.
- Ээ дээ хүү минь энэ бичиг
Энгийн биш учиртай бичиг шүү
Энэ дэлхий амгалан байг гэсэн
Эгэл ард түмний хүсэл юм шүү
Том болоод миний хүү үүгээр аялаарай
Тоймгүй олон нөхдөө дагуулж ирээрэй.
Аав минь урьд энэ бичгийг сийлсэн юм гэж
Аялагч пионеруудад тайлбарлаж өгөөрэй
Ээ дээ хүү минь энэ бичиг
Энгийн биш учиртай бичиг шүү гэж
Буурал эцэг нь ач хүүдээ хэлээд
Булбарай хацрыг нь зөөлөн гэгч илж байна.
Зэрэгцээх уул хаданд цуурай нь хадаж
Жигдхэн хэмнэлээр алхны дуу гарч байна.
Жигтэйхэн хатуу ургаа чулуун дээр
Жигд тодоор “ Энхтайван “ гэж зурайж байна.

1953 он.

## ЭЙЗЕНХАУЭР ДАЙНД МОРДОХ НЬ ЭЭ...

Наполеон баруун европт хөл өргөж
Нарт ертөнцийг хамна гэж хэд дахин мордоод
Эгэл олны хүчинд нам цохиулаад авсанд ороход
Эйзенхауэр гэдэг нэр ор сураггүй байсан юм.

Эрэлхэг Москвагийн дэргэд Напалеон нам цохиуллаа гэж
Ээрүүл барьсан чавганцад хүртэл дороо сонсогджээ.
- Осолдчихов уу? гээд генералууд нь Наполеонд сөгдөхөд
- Орос руу довтолсноос л ялагдлаа гэсэн юм гэдэг.

Хэрээ галууг дуурайж хөлөө хөлдөөнө гэгчээр
Хорвоод Наполеоныг дуурайгчид бас л гараад ирлээ
Энэ дэлхийг мах цусандаа хаман нэгтгэхээр
Эйзенхауэр дайнд мордох гэж байна гэнээ ...

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Энх тайван руу атом далайгчдын хүзүүг
Эрчилсэн олс хүлээж байгааг эс харвал
Ямар ч гэсэн Наполеоныг дуурайгаад, Гитлер
Яадгаа алдталаа ард түмэнд ниргүүлсэн юм даг.

1952 он

## ДАЙНЫ ЭСРЭГ ТАГТАА НИСЭЖ БАЙНА

Дайны эсрэг тагтаа нисэж байна
Далавчны чинь дэвэлтийг зогсоох хүч хаа ч байхгүй
Эх дэлхий чөлөөт дэвэлтэд чинь зам тавьж
Эгэл хүмүүс дүрээр чинь сэтгэлээ илчилж байна.

Дайны эсрэг тагтаа нисэж байна
Дандаа амгалан байхыг хүмүүс хүсэж байна
Далавчны чинь дор социализмын барилга босож
Тив тивийнхэн найрамдлын төлөө гараа барьж байна.

Дайны эсрэг тагтаа нисэж байна
Далавчныхаа дэвэлтээр чи ирээдүйг даллаж байна
Дайн өдөөгчид, жигүүрийн чинь өмнө дагжин чичирч
Даян дэлхийд зэс гуулиа илрүүлсээр байна.

Дайны эсрэг тагтаа нисэж байна
Дажны эсрэг, энхийн уриаг чи түгээж байна
Хүчит жигүүр чинь ертөнцийн хязгаар бүрд дэвж
Хүн бүхэн дайны өөдөөс гараа далайж байна.

Дайны эсрэг тагтаа ни сэж байна
Далавчныхаа дэвэлтээр шуургыг хөдөлгөж байна.
Дажин үхлийн утааг шуургаараа чи хөөж,
Дайнгүй энх зам өөд хүмүүсийг замчилж байна.

Дайны эсрэг тагтаа нисэж байна
Дандаа амгалан байхыг хүмүүс хүсэж байна.
Жигүүрийн чинь доор тэнгис тэнгистээ гараа өгч
Жинхэнэ ирээдүйгээ хүмүүс өөрсдөө байгуулж байна.

1954 он.

## ДАМАНСК АРАЛ

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Нүүгэлтэх дөлгөөн урсгалтай
Уссур мөрний дундаас
Нүдэн адил тормойх
Даманск арлыг үзлээ би

Өргөн нутгийнхаа хил дээр
Тормойх энэ мэлмийд
Өвгөн маогийн сум
Өргөс адил торжээ.

Ирмэх нүдний сормуус шиг
Даманск арлын шугуй
Итгэл эвдсэн суманд
Даамай их шархалжээ.

Нутгийн мэлмий – Даманскийг
Ирмэх нүд шигээ өмөөрч
Нугаршгүй дайчин хилчид
Энхд дайсантай тулалджээ

Ариун сайхан мэлмийд
Торсон өргөсийгаваад
Амиа өргөсөн баатруудда
Эх орон нь сөгджээ.

Итгэж хилээ мануулсан
Эх орны итгэл, энд
Эрсэдсэн баатрын хөшөөн дээр
Гэрэлтэж байхыг үзлээ би.

Үрээ цэрэгт мордуулсан
Эжий аавын найдвар, энд
Эрэлхэг хилчдийн энгэр дээр
Гялалзаж байхыг харлаа би

Нүүгэлтэх дөлгөөн урсгалтай
Уссур мөрний дундаас
Нүдэн адил тормойх
Даманск арлыг үзлээ би.

Үнэхээр энэ Даманск арал
Уссур мөрний нүд байна.
Өнөр Зөвлөлт гүрний
Хилийн нэгэн мэлмий байна.

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

1969 он.
Даманск арал.

## БИД НЭГ ОРЧЛОНГИЙН ХҮМҮҮС

Үүлс мөөгөрч нар халхлалгүй
Уужим тэнгэр цнлмэг байхыг,
Гамшигт дайнаар галав юүлэлгүй
Газар дэлхий амгалан байхыг,
Эх үрсийн сэтгэл түгшилгүй
Элэг бүтэн жаргаж суухыг
Хүн ард минь зүрх сэтгэлээсээ
Хүй орчлонд түгээн дуулцгаая
Энхтайвны их үйлсийн төлөө
Эх дэлхийн хүмүүс сэрэмжтэй байцгаая.
Алаг нүдэнд гуниг суулгүй
Аз жаргал гэрэлтэж байхыг,
Насан туршид нүд дальдралгүй
Найрсаг тэнүүн амьдарч байхыг,
Бие биесийнхээ элгийг хатаалгүй
Бид нэг орчлондоо эвсэж суухыг
Хүн ард минь зүрх сэтгэлээсээ
Хүй орчлонд түгээн дуулцгаая
Энх тайвны их үйлсийн төлөө
Эх дэлхий хүмүүс сэрэмжтэй байцгаая.
Цээж давчдан амьсгал хордолгүй
Цэнгэг агаар амьсгалж байхыг ,
Алтан наран шархдан сэвтэлгүй
Амгалан тэнгэртээ мандаж байхыг
Хорвоо дэлхийнхэн хоорондоо дайталгүй
Хотол даяар энхжин суухыг
Хүн ард минь зүрх сэтгэлээсээ
Хүй орчлонд түгээн дуулцгаая
Энх тайвны их үйлсийн төлөө
Эх дэлхийн хүмүүс сэрэмжтэй байцгаая.
Хийж бүтээснээ хэмхчин нураалгүй
Хойч үедээ гардуулж байхыг,
Нүгэл хийж нүүрээ баралгүй
Нарт хорвоод насаа элээхийг
Хүн болсон хорвоогоо марталгүй
Чин сэтгэлээсээ хайртай байхыг
Хүн ард минь зүрх сэтгэлээсээ
Хүй орчлонд түгээн дуудцгаая
Энх тайвны их үйлсийн төлөө

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Эх дэлхийн хүмүүс сэрэмжтэй байцгаая.

1975 он.

## ГУРГАЛДАЙН ЦЭЦЭРЛЭГТ БУУТАЙ ОРЖ БОЛОХГҮЙ

Энэтхэгдээ би алтан гургалдай,
Энэтхэг бидэнд анхилуун цэцэрлэг.
МУХАММАД ИКБАЛ

Хүн болгоныг хэрвээ
Алтан гургалдай юм гэвэл
Хүй нутаг минь бидний
Анхилуун цэцэрлэг минь юм шүү.
Гургалдайн цэцэрлэгт буутай орж болохгүй,
Гургалдайг хэзээ ч цэцэрлэгээс нь салгаж болохгүй,
Буу онилох газар тэгэхлээр хаана ч байхгүй,
Бузар дайн гарах ёс үнэхээр байхгүй
Эв найрамдал бидэнд нар шиг хэрэгтэй,
Энх тайван мөнх мандах ёстой.
Эгэл түмнийг хэрвээ
Алтан гургалдай юм гэвэл
Эх орон минь бидний
Анхилуун цэцэрлэг минь юм шүү.
Гургалдайн цэцэрлэгт бөмбөг зүүж болохгүй,
Гургалдайг хэзээ ч цэцэрлэгээс нь салгаж болохгүй
Бөмбөг хаях газар тэгэхлээр хаана ч байхгүй,
Бүрэлгэх дайн гарах ёс үнэхээр байхгүй.
Эв найрамдал бидэнд нар шиг хэрэгтэй,
Энх тайван мөнх мандах ёстой
Хүн төрөлхтнийг хэрвээ
Алтан гургалдай юм гэвэл
Хүж дэлхий минь бидний
Анхилуун цэцэрлэг минь юм шүү.
Гургалдайн цэцэрлэгт түймэр тавьж болохгүй,
Гургалдайг хэзээ ч цэцэрлэгээс нь салгаж болохгүй
Түймэр тавих газар тэгэхлээр хаана ч байхгүй
Түйвээх дайн дэгдээх ёс үнэхээр байхгүй.
Эв найрамдал бидэнд нар шиг хэрэгтэй,
Энх тайван мөнх мандах ёстой.

1978 он.

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

## УРИА

Гийгүүл, алтанхан нар минь гийгүүл,
Гэгээн тунгалаг гэрлээ нэмэнхэн гийгүүл
Гэр оронд минь гэгээ тусганхан гийгүүл
Гэр бүлийн минь заяаг дэвжээнхэн гийгүүл

Орон хотыг минь улам дуртууланхан гийгүүл
Олон түмнийг минь улам өнөржүүлэнхэн гийгүүл
Сайхан эх орныг минь ивээнхэн гийгүүл
Саруул энх амгаланг оршоонхон гийгүүл

1979 он

## ДЭЭВЭРТ НАРЛАСАН ТАГТАА

Дээвэрт нарлан тагтаа буугаад
Дэлхийн амгаланг зарлан байна.
Дэргэд налайн хань минь суугаад
Дэлгэсэн яриа хүүрнэн байна.
Дээвэрт нарласан цэнхэр тагтааг
Дэлбэрэх чимээ битгий үргээг
Дэргэд суугаа ханийн минь зүрхийг
Дэлгэр дэлхий дандаа баясгаг
Хайртай хотын минь жавхаа нэмээд
Харах нүдэн баясган байна.
Хажууд цугларан хүүхэд наадаад
Хөөрхөн тагтаа зураглан байна.
Хайртай хотын минь цэнхэр тэнгэрийг
Харлах утаа битгий нөмрөг
Хажууд наадсан үрсийн маань зүрхийг
Халамж ивээл дандаа баягаг
Цэлгэр талбай амгалан уужраад
Цэнгэг агаар сэнгэнэн байна.
Цэцэрлэгт хослон залуус зугаалаад
Цээжний үгсээ шивнэн байна.
Цэлгэр талбайн минь амгалан тайвныг
Цэнэг дэлбэрч битгий цочоог
Цэцэрлэгт шивнэсэн залуусын зүрхийг
Цэнгэл жаргал дандаа баясгаг.

1981.11.10

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

## ХАЛХЫН ГОЛ

Эцгийн цагаан өргөөний
Ээлтэй уужим хаяа шиг
Туждаа цэлийх Дорнын тал
Туулах тусам уужирна.

Дорнын талын хаянд
Дайчин эцгийн сэлэм шиг
Домогт цэнхэр Халхын гол
Таших наранд гялалзана.

Эхийн бүүвэй шингэсэн
Ээлтэй дулаан өлгий шиг
Нутгийн сайхан Дорнын талд
Нутаглах тусам жаргана.

Энгүй талын хаянд
Ээжийн цагаан сүү шиг
Талыг туулсан Халхын гол
Түмэн олноо умдаална.

Уужмын холдоо цуурайтсан
Уртын дууны эгшиг шиг
Сэлгүүн уудам Дорнын тал
Сэтгэл зүрх булаана.

Дорнын талын хаянд
Дотнын ханийн мэлмий шиг
Халхын сайхан Халхын гол
Хайраар бялхан мэлмэрнэ.

Эцгийн цагаан өргөөний
Ээлтэй уужим хаяа шиг
Туждаа цэлийх Дорнын тал
Туулах тусам уужирна.

Дорнын талын хаянд
Дайчин эцгийн сэлэм шиг
Домогт цэнхэр Халхын гол
Таших наранд гялалзана.

1979 он.
Халхын гол

Буйр нуур

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Эх орны минь дорнод хил дээр
Эргээ бялхан мэлтийх Буйр нуур
Түмэн хонгор адууны нуруу шиг
Талын хөрсөн дээр гөвийж харагдана.

Хүний нутгийн сэжүүр цухуйх
Хөх тэнгэрийн хормойд байгаа
Хонгортох түмэн адуугаа бүртгэх шиг
Харуулын шонгоос хилчин дурандана.

Хүний нутгийн тэр зүгээс
Хөвсрөгдөн үлээх хар салхинд
Тэртээ захаасаа үргэсэн адуу шиг
Тэнгэрийн доор Буйр нуур давалгаална.

Үргэн хуйларсан хонгор сүрэг
Унаган зэлэндээ эргэн хурах шиг
Тэнэгэр тал дээр Буйр нуур давлавч
Тэр л газраа нуруу нь гөвийнө.

1979 он
Буйр нуур

## БАЯНЦАГААНЫ НУРУУ

Баянцагааны нуруу
Алдрын оргил шиг өндөр
Баянцагааны нуруунд
Авирах зам өгсүүр

Алтайн нуруунаас энд
Хилийн цэрэгт ирсэн
Аавын олон хөвгүүд
Дандаа өгсөж ирсэн гэнэ.

Хөвсгөлийн цэнхэр уулнаас
Илгээлтээр ирсэн малчид
Халхын гол өөд нүүнгээ л
Дандаа өгсөж ирсэн гэнэ

Баянцагааны нуруу
Алдрын оргил шиг өндөр
Баянцагааны нуруунд
Авиран гарахад өгсүүр

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Нуруун дээр нь гарахлаар
Өргөн тал шиг цэлгэр
Нутаг усны бидэндээ
Өгөөж шим дэлгэр

Баянцагааны нуруунд
Өндөрлөг бүхэн нэртэй
Баянцагааны нуруунд
Дэвсэг бүхэн хөшөөтэй.

Сөөм газар бүхэн нь
Өнгөрсөн тулааны түүхтэй
Сөөг дэрс болгон нь
Өөрийн нэг домогтой.

Баянцагааны нуруу
Алдрын оргил шиг өндөр
Баянцагааны нуруунд
Авиран гарахад өгсүүр.
Тийм ч учраас тээр жил
Дархан хилд маань халдсан
Далайн арлын самуурай нар
Давж чадалгүй ялагдсан юм.

1979 он
Баянцагааны нуур

## ДЕПУТАТ

Өрнүүн амьдралын байнга хувирах хуулинд
Өртөгдөөгүй юм орчлонд огт байхгүй юм.
Арц модны өнгө шиг мөнх улирсангүй
Зарц гэдэг үгийн утга нь бас хувирчээ.

Тулах модноос дөнгүүр унаагүй ядуус
Тулга тогооноос дээгүүр суудалгүй зүдүүс
Харц нэртэй зарц явсан юм гэнэ лээ
Хаад баядад ер итгэгдээгүй юм гэнэ лээ.

Харц гэдэг үг ангилах үүргээс чөлөөлөгдөж
Зарц байсан ард түмэн зарцтай болжээ.
Баядын зарц ядуугийн эрхэнд очдог байсан бол
Ардын зарц итгэлийн хүчинд ирдэг болжээ.

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Алаг үрсийнхээ аль авхаалжтайг олон түмэн маань
Ардын депутат болгож үйл хэрэгтээ зардаг юм.
Ард түмэнд зарц болж итгэгдэх тийм хүн
Ажил үйлсээрээ ардынхаа дундаас төрдөг юм.

1957 он.

**Төрийн жолоог ард түмэн барьж байна**

Хүн бүрийн гар дахь сонгох эрхийн үнэмлэх дээр
Хөх улаанаар алаглах соёмбот далбаа намиран байна.
Тэмцэлд ялан бадраасан сүлд тугийнхаа ишнээс
Тэгш эрхээр хүн ард атган барьж байгаа нь энэ байна.

Ард түмэн минь төрийнхөө жолоог барьж байна гэж
Анх удаа сонгуулийн үнэмлэх гардаж аваад
Аз завшаант энэ өдрийг тоолон хүлээсэн
Арван наймтай дүүгийн минь баясал хэлж байна.

Өргөн түмэн минь төрийн жолоо барьж байна гэж
Өчнөөн удаа сонгуульд саналаа өгсөн мөртлөө
Өнөөдөр л шинээр оролцох юм шиг яарсан
Өвгөн буурал аавын минь баясал хэлж байна.

Олон түмэн минь төрийн жолоо барьж байна гэж
Онцын хүндэт энэ үнэмлэхийг гар дээрээ тавиад
Эрхмээс эрхэм энэ төрийн сонгуулийн өдөр
Эх орны чөлөөт иргэн би хэлж байна.

Хүн ард минь төрийн жолоо барьж байна гэж
Хүндэт энэ үнэмлэхийг хожим гардан баярлах
Хүсэл сайхан ирээдүйд жигдхэн алхаагаар тэмүүлсэн
Хүүхэд багачуудын минь ялалзсан жагсаал хэлж байна.

Хүн бүрийн гар дахь сонгох эрхийн үнэмлэх дээр
Хөх улаанаар алаглах соёмбот далбаа намиран байна
Тэмцэлд ялан бадраасан сүлд тугийнхаа ишнээс
Тэгш эрхээр хүн ард атган байгаа нь энэ байна.

1966 он

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

## АРДЫН ХЯНАН ШАЛГАГЧДЫН ДУУ

Алба бүхнийг амжилт бүтээлтэй байлгах гэж
Ардын хянан шалгагчид сэтгэл амаргүй
Алдаа дутагдал гарахаас урьдчилан сэргийлж
Аль ч цагт бид чөлөө завгүй.
Ардын хянан шалгагчид бид
Аль ч цагт чөлөө завгүй
Гэгээн төрийнхөө хатан их сүлдийг
Гэрэлт нар шиг орой дээрээ залаад
Ард түмнийхээ ажил үйлст зүтгэсэн
Ардын хяналт шалгалтынхан аз жаргалтай
Ардын хянан шалгагчид бид
Аль ч цагт чөлөө завгүй.
Хуучны гай хүнд суртал удахгүй устаж
Хүн бүхэн өөртөө хяналт тавьдаг болно.
Тэр цагт бид хүнд ачаагаа бас хөнгөлж
Тэдний адил зөвхөн өөрийгөө хянах болно.
Ардын хянан шалгагчид бид
Аль ч цагт бас аз заяатай

1981 он

## ШИНЭ ОН

Хоёр он солилцдог
Хоромхон төдий зааг бий.
Хөх манхан тэнгэрээс
Хөвөн цагаан үүлнээс
Хуучин онд шүхэрлэсэн
Хундан цагаан цасны ширхэг
Шинэ он гарсан хойно
Газар дэлхийд бууж ирдээг.

Хоёр он дамнадаг
Холын хол зай бий
Хүний гэрэлт ертөнцөөс
Хөрст газар дэлхийгээс
Хуучин онд харвасан
Холхи огторгуйн оньсон хүлэг
Шинэ он гарсан хойно
Од саранд дүүлэн хүрдээг.

Хоёр оныг хооронд нь

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Хүний хөдөлмөр холбодог юм.
Холыгоо харан байж
Хойчийгоо бодон байж
Хуучин онд асгаруулсан
Хөдөлмөрийнхөө хөлсний үр шимийг
Шинэ он гарсан хойно
Хүн ард эдлэн жаргадааг.

Тийм учраас
Шинэ он залуу нь юм.
Шинэ он залгамжлагч нь юм
Шинэ он бүтээлч нь юм.

1962 он

## САМПИН

Осолгүй ирэх нэгэн өдөр
Олон хүн ажилгүй болно
Тэр олон ажилгүй хүнийг
Тэжээх үүрэг Гүрэнд ногдоно.

Орон улс маань хөгжих тутам
Орлого зарлага гэж хязгааргүй болно
Энгийн сампин музейд шилжиж
Электрон машин тооцоолох болно.

Нарийн техник амьдралд нэвтэрч
Нээх ухаан эрчээ авч байна.
Нарлаг орон маань хөгжилт гүрэнтэй
Нэгэн гараанаас хурдаа авч байна.

Авсаар хүн электрон машиныг
Ажиллуулж дийлэхгүйг бид мэднэ
Тийм ч учраас модон сампинчид
Техникийн эрин дараа болно.

Гүрэн улс маань иргэн хүнээ
Гудманд хэзээ ч хаядаггүй болхоор
Техникийн эринээс өөрсдөө хоцорсон
Тэр хүмүүсийг тэжээх гэж зовно.

Хоёр он солигдох тоолон

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Хүнд нэгийг хэлсээр байна
Хожим ирээдүй улам ойртож
Хүний ухаан тэлсээр байна

Ийм болохоор ухаант хүмүүн
Элэгдсэн сампинг бодох нь зүй
Элдвийг эргэцүүлж боддог хүнд
Энэ шүлэг лав хэрэгтэй.

1972 он

## ХӨШӨӨНИЙ БИЧЭЭСТ ЗОРИУЛСАН ҮГ

Ардын журамт цэргээс төрсөн
Ардын хувьсгалт армийн алдрыг
Түүхийн хуудсанд ган үзгээр бичиж
Түмний нүдэнд гантиг чулуунд сийлэв.

Ардын журамт цэргээс төрсөн
Ардын хувьсгалт армийн гавъяаг
Ган үзгээр түүхэнд мөнхөлж
Гантиг чулуугаар газарт мөнхлөв.

Ардын журамт цэргийн гавъяаг
Ардын хувьсгалт армийн алдрыг
Ган үзгээр түүхэнд мөнхлөв
Гантиг чулуугаар газарт сийлэв.

Ардын журамт цэргийн гавъяаг
Ардын хувьсгалт армийн алдрыг
Асах галын дөлөнд бадрааж
Алтан нарны туяанд цацрааж
Эх орны гантигт сийлэв,
Энэ дэлхийн хөрсөнд мөнхлөв.

1980 он

## ЭХ ОРНЫ СҮР ЖАВХАА

Цэргийн жагсаалын дуу

Эх орны минь сүрлэг жавхаа

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Эрэлхэг дайчдын жагсаалд байдаг юм.
Эгэл олны минь заяа жаргал
Энхрий орныхоо амгаланд байдаг юм.

Жанжин Сүхийн алхах чимээ
Жагсаалын дууны аялгуунд байдаг юм.
Жаргалтай ардын инээх баясал
Цэргүүдийн нүдэнд гэрэлтэж байдаг юм.

Ардын армийн ялалт бүхэнд
Ачит намын минь гавъяа байдаг юм.
Атгаж мөрлөсөн зэвсэг бүхэнд
Аугаа зөвлөлтийн хаяг байдаг юм.

Ах дүү армийн аварга хүчинд
Алтан дэлхийн минь заяа байдаг юм.
Ард түмний халуун нэгдэлд
Атаат дайснуудын мөхөл байдаг юм.

Дайчин бидний сүрт дуулал
Даяар энхийн төлөө байдаг юм
Даян дэлхийн шудрага түмэн
Дандаа бидэнтэй хамт байдаг юм

Эх орны минь сүрлэг жавхаа
Эрэлхэг дайчдын жагсаалд байдаг юм.
Эгэл олны минь заяа жаргал
Эх орныхоо амгаланд байдаг юм.

1981 он

## СОЛОНГОС ТҮМЭНДЭЭ

Найман зуун сая гаруй хүний
дуу хоолойг нэгтгэсэн
Нар ба туг нь
бидний гарт байгаа хойно
Хэн ч гэсэн
мэдээжийн
хүний зүрх жаргаж
Хаа газрын амьтны
Доголон
Нулимс хатах бий
Аалагын эзэд

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

далай дээгүүр
хядлага таривч
Энэ дэлхийн
элэг нэгтний
их сэтгэмж нь
Элгэн хад шиг
танай фронт дээр
нягтарсан хойно
Ази ба
Нөхдийн минь эх орон –
Солонгос
Атлантын эвслийн
түрэмгий хөлд
хэрхэвч ойчихгүй
Үхлэн янк
фашистчилсан хэргийнхээ
эцэст нь
Үхсэн хүүрээ л
далайн тэртээ рүү
зөөхөөс биш,
Энх тайвны, төлөө
Ган болд шиг нягтарсан,
Үнэнчийн тангараг
ардын зүрхийг аваачихгүй
Эрх чөлөөний туг
Та –нарын гарт дэрвэлзэж байна.
Энэнийхээ л төлөө, энхийнхээ төлөө
Ай даа,
давшаад бай
солонгосчууд аа
Амьдралаа,
цусаа,
зүрхээ
Аз жаргалдаа бэлэглэцгээ
Эгэл жирийн бидний дуу
ямар ч хэлэнд
нийцдэг нь
Энх тайсан
хэн бүхэнд
хэрэгтэйнх юм.
Аугаа Зөвлөлт тэргүүтэй
хамтын хүчинд
нэгдсэн хойно
Ялалт ба туг нь
биднээс сална гэж
байхгүй шүү.

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

1951 он.

## МОНГОЛ БОЛГАР АХАН ДҮҮС

Өвгөн буурал Алтай
Өндөр Родопи хоёр
Өөрсдийгөө хэзээ ч хараагүй юм.
Өвч монгол түмэн
Өнөр болгар хүмүүс
Өнө мөнхийн ахан дүүс болсон юм.

Ган адил ширээгдсэн
Ган бат найрамдал
Газар нутагт огт холддоггүй юм.
Гал халуун сэтгэлээр
Гараа атгалцсан хүмүүс
Газар дэлхийд ер алздаггүй юм.

Тэнгисийн хойг Балкан
Төв Азийн их тал хоёр
Түмэн газрын алс холд оршдог юм
Төрөлх Улаанбаатар минь
Төрсөн дүү Софитойгоо
Төө зайгүй ойр дотно байдаг юм.

Өвгөн буурал Хэнтий
Өндөр Вытоша хоёр
Өөрсдийгөө хэзээ ч хараагүй юм.
Өвч монгол гүрэн
Өнөр Болгар улс
Өнө мөнхийн ахан дүүс болсон юм.

1981 он.

## КУБА

Дэлхийн бөмбөрцөгийн нөгөө хагаст
Дэлбээлсэн цэцэг шиг гүрэн бий
Дэлгэрч явах сайхан заяатай
Диваажин шиг сайхан орон бий.

Хөх тэнгэрээс Кубыг харахад
Хүний гартай адил харагдана

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Хөдөө нутаг эдлэн газар нь
Алганы хээ шиг ирийж үзэгдэнэ.

1982 он.

## ЭРЛИЙН ҮЗҮҮР

Эрх чөлөөнийхөө төлөө
Тэмцэгч нөхөртөө

Торолзох олны тоосон дундаас
Торойх барааг чинь би үзнэм.
Тоост хорвоод үнэнийг хайж
Тормойх нүдийг чинь би харнам

Агсам хөлгийн дэлд нь бөхийж
Ахуй ертөнцөөр чи минь хэснэм
Үхэх төрөхийн үнэний хооронд
Эрх чөлөөгөө чи минь хайнам.

Дуулим хорвоо туйлгүй уудам
Дөрвөн зүг найман зовхистой
Амьдрал гэдэг агсам хүлэг
Аянд цуцахгүй шандас сайтай.

Аугаа дээдэс чинь ухаанаар баян
Агсам хүлгийн нуруунд чадалтай
Хорвоог хэрж үнэнийг хайсан
Хүлгийн тоос нь одоо ч босоостой.

Хүлгийн жолоог эцгийн гараас
Хүлээж авах үрийн ёс оо
Эцгийн эрлийг хүү нь залгах
Энэ хорвоогийн жам ёс оо

Эрлийн үзүүр эцэсгүй урт
Эцэг чинь тэгээд замд цуцсан юм
- Хүү минь одоо давхи даа гэж
Хүлгийнхээ жолоог чамд өгсөн юм.

Эцгийн дөрөөний сэнжийг элээж
Эрх чөлөөгөө чи минь хайнам
Хорвоод өөр шигээ эрэлд гарсан
Холхих олны тоосонд дарагднам.

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Орчлон хорвоод үнэнийг эрсээр
Олдошгүй бие чинь цуцах юм бол
Хүлгийн жолоог эцгийн адил
Хүүгийнхээ гарт чи минь өгөөрэй

Торолзох олны тоосон дундаас
Торойх бараагаа томруулан давхи
Тоост хорвоод үнэйиг хайсан
Тоймгүй олны магнай нь давхи
Эрлийн үзүүр эцэсгүй гэлээ ч
Эрсэн хүн заавал олдог юм
Эцгийн улбааны торгон үзүүрийг
Аавын хүү, наран өөд хөтөлдөг юм.

1967 он.

## ЭНЭТХЭГИЙН ШӨНӨ

Шивнээт шөнийн тэнгэрт одод гялалзан
Ширүүн Гангын урсгал долгио татаж байна.
Энэтхэг нутгийн тэргэл сартай шөнө
Эрхгүй Бомбейн ядуус ажил хаян жагсаж байна.
Хонгор Энэтхэгийн эх болсон эмэгтэй
Хувь заяандаа итгэн хүүгээ хүлээн хоцроход
Бугын эвэр шиг салаатсан Гангын урсгал шиг
Босогчдын жагсаалууд өргөжин нийлж байна.

Одод сүүмэлзэх Энэтхэгийн тэр шөнүүдэд
Олны хүчнээс нутгийн эзэд сүрдэн чичирч байна.
Бенгал газрыг хээглэн залгих гэсэн
Британ ноёдын ч зүрх нь шимширч байна.
Аллах тэнгэрт итгэсэн хөл нүцгэн өвгөн л
Аз жаргал гуйж догшин бурхандаа залбиравч
Шанааны нь үс улам л бууралтсаар байна.
Шармал бурхан нь улам л зэвэрсээр байна.

Энэтхэг нутгийн тэргэл сарны дор
Эзгүй хээр босогчдын бамбар гялалзаж байна.
Энэтхэг орон, сайхан эх орон минь
Эзэрхэг дайсны гинжинд байх ёсгүй гэж
Сүмийн хонх сонсогддог Энэтхэг нутагт минь
Сүртэй улаан туг намиран хийсэх ёстой гэж
Эвлэж нэгдсэн нөхдүүд тойрон сууцгааж

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Инд мөрний урсгалаас хүчтэй дуулж байна.

Хөл ихтэй Бомбей хот түгшүүртэй байна.
Хөлөг онгоцууд ачаатайгаа зогсоол дээр шавсан байна.
Заводын байранд ачаа зөөгчид ирсэн байлаа.
Цугларагсдын зүг хандаж өвгөн үгээ эхэллээ.
- Булчинт гараа хумхидаггүй хөдөлмөрийн хүмүүс
Боолын боол байх үйлтэй юм гэж үү?
Хүн хүүхдээрээ, ногоо нялхаараа үхдэг нь
Хөгжиж байгаа нь тэр үү, Энэтхэг орон?

Одон хээлэлт тэнгэрийн хормойг шуусаар
Энэтхэг оронд үүр манхайтал цайж байна.
Олон ажилчдын цугларсан заводын байранд
Эрх чөлөө, энх тайван гэдэг үг дуурсаж байна.
Манхайтал цайж байгаа үүрийн гэгээг
Октябрийн туяа гэж Энэтхэгчүүд нэрлэж байна.
Мандан гарах гэж байгаа ариун нарыг
Эрх чөлөөний нар гэж Индусүүд ойлгож байна.

1953 он.

## ТОКИОГИЙН ШӨНӨ

Номхон далай алсын туяанд гялбаж
Нойрмог сар үүлсийн завсраас хялайна.
Бүтэн шөнө дөө хар даран зүүдэлсэн шиг
Бүргийн дунд Токио хот нэвсийнэ.

Хүйтэн далайн эрэг нүдэнд зэвүүн буудалд
Хүний газрын дайны онгоц арзайн зогсоно.
Аймтгай харуул, дэргэд нь мод шиг ёрдойж
Америкийн далбаа , дээр нь навсайн хийснэ.

Гэвч Токио хотын зах дахь жижиг байшинд
Гэдэс өлсгөлөн япон эмэгтэй унтаагүй байна.
Гэгээвчээрээ үүрийн туяа орж байгааг
Хэтэрхий шамдсан ажилдаа мэдэхгүй байна.

Дөрвөлжин цах модны өмнө бөгцийн сууж
Тэнгэрийн өнгөтэй цэнхэр хивс нэхнэ.
Тэрсүүд аюулын эсрэг хэлэх үгээ бэлдэж суух шиг
Тэр эмэгтэй яаран яаран нэхнэ.

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Далайн ёроолоос гарах шиг өглөөний наран мандаж
Токио хотын ядуус шинэ өглөөг угтав.
Өлсгөлөн эмэгтэйн нэхсэн цэнхэр хивсэн дунд
Энхийн цагаан тагтаа дүүлэн дүүлэн нисэв.

1953 он

## АФРИКТ БИЧСЭН ШҮЛГҮҮД

### 1. ЭТИОП ОРОН

Африкийн Эвэрийн сайхан нутаг
Алс холын Этиоп орон
Анхны учралаар сэтгэл булааж
Ах дүүгийн барилдлага барив.

Аддис – Абебын ногоон цэцэрлэг
Амхаар хэлний уянгалаг яриа
Торомгор бүсгүйн золбоот бүжиг
Тольт зүрхний хайр булаав.
Улс орных нь өөдрөг царай
Ухаалаг залуусын нь хувьсгалч зан
Ард түмнийх нь гэрэлт ирээдүй
Айлчин мидний сэтгэл баясгав.

Амь үрэгдсэн хувьсгалчдын музейг
Анхны кебелийн хүүхдийн яслийг
Амхаар хүмүүсийн алаг том нүдийг
Ашид мартахгүйн андгай тавив.

Африк тивийн махир өнцгийг
Африк тивийн Эвэр гэх юм
Амьдарч тэнд идээшсэн хүмүүсийг
Африкийн Эвэрийн хүмүүс гэх юм.

Алс холын Этиоп орон
Африк тивийн Эвэрт орших юм.
Бүх Африкийн тэргүүн гэдгээ ч
Байлдаж олсон хувьсгал нь батлах юм.

Эвэр гэдэг тэргүүнд ургаж
Эх биеэ хамгаалдаг билээ
Эх биеийн тэргүүнд ухаан байж
Бүх биеэ жолооддог билээ.

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

1979 он.
Аддис- Абеба

## 2. АФРИК БИЕЛГЭЭ

Этиоп улсын үндэсний театр
Эрхэм зочдодоо суудал бэлэглэж
Энд тэндхийн гийчин бид нар
Эгнэн сууж урлаг сонирхов.

Хуургинах хөшиг алгуур нээгдэж
Хувьсгалын дуу эхлээд дуулав
Нүргэлсэн хэнгэрэг дараа нь дэлдэж
Нүцгэн шахуу хүүхнүүд бүжив.

Африк хүүхнүүдийн бүжих нь адтай
Авсаар болихгүй удах шинжтэй . . .
Гэтэл нум сум, өд зүүсэн харчууд
Гэдрэг савчин цовхрон ирэв.

Эхнэрүүдийн онгод улам сэргэж
Эртний амьдрал тайзан дээр амилж
Эх эмээрээ хосолж байгаад
Элдэв янзаар баахан бүжив.
Урлаг өөрийн хэлтэй болхоор
Ухаант ардын бүтээл учраас
Бүжгийн хөдөлгөөн өвөрмөц ч гэсэн
Бүрэн учрыг нь ойлгож суув.

. . . Гэрэл унтарснаа дахин асаж
Гэгээ цацарсан бүсгүй гарч ирэв
Цээжин биелгээ гайхмаар биелж
Чимээгүй танхимд алга нижигнэв.

Түмний газрын урлагийн бүтээлд
Төрөлх ардынхаа биелгээг үзээд
Африк түмнийг үнсээд авмаар
Алаг зүрх минь баярлан догдлов.

Алсын хоёр тивд боловч
Алдын бүтээл ижилхэн байна.
Манхан тэнгэр доор африк бүсгүй
Монгол хүн шиг биелдэг байна.

## 3. АСКАЛА БҮСГҮЙ

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Аскала бүсгүй – алаг нүдэн бүсгүй
Амхаар залуугийн хайртай бүсгүй
Борхон биетэй бүжигчин бүсгүй
Бодол санаанаас гарахгүй бүсгүй.

Тайзан дээрээ тун ч шидтэй
Талын гөрөөс шиг түлхүү цээжтэй
Бултаж дүүлэх нь бусдаас сондгой
Бултын дундаас нэг л онцгой

Бүжиглэх гэдэг нь бүүр ч идтэй
Бүхнийг нүдээрээ өгүүлэх нь адтай
Хайр хүрмээр сайхан жавхаатай
Харах нүдэнд өртөх заяатай.

Аскала бүсгүй, ай даа адтай бүсгүй,
Амраг сэтгэлийн одтой бүсгүй
Насны хань тогтохгүй зовох бүсгүй
Нартын нэгэн сайхан бүсгүй.

4. АФРИКААС АВСАН БЭЛЭГ

Африкаас авсан бэлэг минь
Аягын чинээхэн бөмбөр
Аваачиж өгөх хүн нь
Аавын хайртай Амар.

Бөмбөр гэдэг амьтай
Бөмбөрдөхлөөр дуугарна.
Аягын чинээхэн бөмбөр
Аавын сэтгэлийг ярина.

Ууж идэх юм Африкт
Ус агаар шиг зөндөө
Өмсөж зүүх юм Африкт
Өргөн дэлхий шиг баян.

Бөмбөр харин амьтай
Бөмбөрдөхлөөр дуугарна.
Урлаг гэдэг үнэтэй
Урлаг өөрөө амьтай.

Африкаас авсан бэлэг минь
Аягын чинээхэн бөмбөр
Аваачиж өгөх хүн нь

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Аавын хайртай Амар

1979 он
Улаан тэнгис

**АДЕН**

Африк орж буцах замдаа
Аденд онгоц нэг цаг зогсоно
Араб нутгийнхны ойлголтоор
Аден гэж диваажинг нэрлэнэ

Их далай руу сунатал жийсэн
Эх газрын нарийхан тохойд
Жийсэн хөлийн өлмий гэмээр
Жижигхэн толгойн нүцгэн ар дээр

Өнө эртний боловч шинэхэн хот
Өмнөдийн наранд цонох шахам байна
Энэ хотыг Аден гэж нэрлэнэ
Энэ их усыг Адены булан гэнэ

Аден - Өмнөд Йемений нийслэл
Аден - өөрсдийнхөндөө диваажин,
Дэргэд нь их далай цэнхэрлэнэ.
Дээрээс нь хурц нар төөнөнө.

Өмнөдийн хурц нарны туяа
Өргөн далайг толь шиг гялбуулна
Нар туссан тэр том толины өмнө
Нийслэл Аденийхан хүрэнттэлээ төөнүүлнэ.
Ханатай байшинг нэвт төөнөсөн
Халцгай гэмээр энэ их халуунд
Хичнээн ч жил энэ нутгийнхан
Хүрэнттэлээ төөнүүлсэн юм бэ,бүү мэд

Эзэн хаанаа ширээнээс гулсуулж
Эрхгүй боолыг чөлөөлснийг нь би мэднэ
Эх орондоо эзэн суусан
Эндхийн хүмүүст би баяр хүргэнэ

Аден хот яагаад ч юм бэ
Алаг зүрхэнд минь дотно санагдана
Араб нутгийн хаана нь ч явсан

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Адилхан нэг үзэгдэл сэтгэл хөргөнө

Ханатай байшинг нэвт төөнөсөн
Халцгай гэмээр энэ их халуунд
Хар нөмрөгтэй шажинт бүсгүйчүүл
Хаана л бол хожуул шиг шовойно.

Ээ дээ хөөрхий, энэ бүсгүйчүүл
Эрлэгийн харанхуй шиг хар нөмрөгөө
Хуу татаж хаяагүй байсан цагт
Хотол Арабынхан сайнаа хэзээ ч үзэхгүй

Харин Адены хүмүүст би итгэнэ
Хар нөмрөгөө хуу татаж хаяна.
Аден хот тэгэхэд диваажин болно.
Араб нутгийн од болж гялалзана.

1979 он
Аден хот

## САУДЫН АРАБ

Саудын Арабад би очоогүй
Сайхан нутагт нь хөл тавиагүй
Саудын Арабыг би сайн мэднэ
Саудын Араб – Хааны Араб

Өнөөдөр би Саудын Арабын
Үүлтэй тэнгэрт нь нисэж явна.
Үүлэн цоорхойгоор хаая нэг
Үзэгдэх төдий газар эрээлжилнэ

Үүрийн туяаг амдан нисэхэд
Өргөн нутаг нь бас ч зайтай
Үүл нөмөрсөн Саудын Араб
Үзэгдэх юмгүй ихэнхдээ харанхуй
Сансрын солирыг бурхан болгож
Эндхийнхэн хичнээн ч удаа шүтэв дээ
Сауд хаадын боол нь болж
Энэ хүмүүс хичнээн ч жил зүдэв дээ

Шажин шүтлэгээр оролдохгүй гэж
Өрнөдийн хөрөнгөтнүүд ярих дуртай
Шажин шүтлэгийг минь хамгаалах нь гэж

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Эндхийн Арабчууд бас дуртай

Сансрын солирыг бурхан болгоод
Саудын удмыг хаанд өргөмжлөөд
Эцэст нь тэгээд юу боллоо?
Энэ гутамшгийг нь дэлхий мэднэ.

Хаадын ёсонд харшлаа гэж
Хайр сэтгэлтэй боллоо гэж
Хоёр сайхан цэцэг шиг залууг
Хоёр сайхан эр, эм хоёрыг

Хорьдугаар зууны энэ сайхан
Хосгүй тунгалаг алтан нарны дор
Хаадын үе дамжсан мохоо сэлмээр
Харах нүдний өмнө цаазалж

Сая сая хайрын сэтгэлтний
Сайхан зүрхийг шархлуулсан шүү дээ
Саудын Араб хүн төрөлхтнөөс
Салж гээгдсэнээ харуулсан шүү дээ

Ээ зайлуул, Саудын араб
Эртний харанхуй Саудын араб
Саудын Араб арабчуудын араб биш
Саудын Араб – Хааны Араб

1979 он
Саудын Арабын тэнгэрт

## МОРЬ

Удам сайхан хорвоод
Эхээс намайгаа мэндлэхэд
Уяаны зулзаган шон дээр
Эмээлтэйгээ угтсан морь минь

Үүрийн цагаан туяанаар
Чи минь наддаа харагдаж
Үүрсэх сайхан дуу чинь
Чихэнд дандаа хадах юм
Үүрийн цагаан туяанаар
Эхээс унаад уйлахад чинь
Үүрсэх сайхан дуугаараа

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Бүүвэйлж байсан нь гарцаагүй

Унасан сайхан нутагтаа
Хөл дээрээ анх тэнцэхэд минь
Угаас миний хүлэг чи
Шилгээж баярласан нь гарцаагүй

Уул шиг өндөр нуруундаа
Намайг анх мордоход
Удам цагаан тал шиг болж
Навтайж өгсөн нь гарцаагүй

Амьдралын урт харгуйд минь
Аз жаргал билэгдэж
Амгай юугаа хангинуулан
Эвшээж баярласан нь гарцаагүй

Хуйвтай ууртаа даахгүй
Бараагий чинь харан гуруйлахад
Хурдан морины уяан дээр
Өөрөө ирсэнийг чинь санаж байна

Хуй салхи шиг уралдаанд
Газар шаргалтан дайвалзахад
Хуруу чинээхэн намайгаа
Хээр хаягүйд чинь баярлаж байна.

Ардын цэрэгт мордох гэж
Адгаж баярласан нэгэн шөнө
Айлын гадаа чамайгаа
Анх мартсандаа гэмшиж байна

Амьтан хүн босохоос урьд
Чи минь наддаа үүрсэж
Амрагийн тэр болзооноос
Дуудаж сэрээснийг санаж байна

Ээлтэй чиний нуруунд
Эр бие минь жарган өсөж
Эрдэнийн хүлэг чамайгаа
Элэг зүрхнээс хайрласан сан

Алхан эрдэнийн толгойд чинь
Ташуур зангалгүй байсаар
Ажил эрдмийн эрхээр
Хөдөө нутгаасаа гарсан сан

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Орон хотод суурьшсан
Анхны тэр шөнөө би
Онгон хүлгээ хулжлаа гэж
Хар даран зүүдэлсэн сэн

Моринд хайртай намайгаа
Амраг хань минь өрөвдөж
Мондийн тэр зүүднээс
Олон удаа сэрээсэн сэн

Орон хотод одоо
Морьтой хүн харахлаар
Онгон хүлгээ хулжлаа гэж
Хар даран зүүдэлсэн сэн

Моринд хайртай намайгаа
Амраг хань минь өрөвдөж
Мондийн тэр зүүднээс
Олон удаа сэрээсэн сэн.

Орон хотод одоо
Морьтой хүн харахлаар
Онгон хөдөө нутаг минь
Сэнхийтэл үнэртэх юм.

Айлын гадаа чамайгаа
Харанхуй шөнөөр орхиж
Амрагийн болзоонд оройтсон
Залуу насаа өрөвдөх юм.

“ Морь гэдэг, хүү минь,
Хүнд л заясан унаа
Морь шиг ухаантай адгуус
Энэ дэлхийд байхгүй

Хүлэг морин гэдэг
Тэнгэрийн оддыг ч андахгүй
Хүний нутгаас гүйхдээ
Одоор баримжаа авдаг юм. “ гэж

Аавын ярьсан яриа
Сэтгэлд сэрхийн бодогдож
Ажил төрлийн чөлөөндөө
Хөдөө нутгаа зорих юм.

Айл л байвал гадаа нь

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Морь байдаг учраас
Айлын үүд татахаас урьд
Чам руу гаа л би очих юм.
Аглаг хөдөө нутгаас минь
Нулимс гаргаж үдсэн
Алхан эрдэнийн толгойг чинь
Зөөлхөн нэг илэх юм.

Удам сайхан хорвоод
Эхээс намайгаа мэндлэхэд
Уяаны зулзаган шон дээр
Эмээлтэйгээ угтсан морьд минь

Улс Монгол орныхоо
Ивээл хайранд жаргаж
Улаанбаатар нийслэлийнхээ
Элгэн халуунд өнөржиж

Улирах цаг үсэнд минь
Буурал шигтгэнэ гэдгийг ч
Ухаарч завдаагүй мөртлөө
Чамайгаа би мартаагүй.

Донойн хөндий шиг зайтай
Дөрвөн өрөө байшиндаа
Дотнын сайхан хань минь
Үр хүүхэдтэйгээ бужигнаад

Аавын ор гэж хүндэлдэг
Миний орны толгой дээр
Алхан эрдэнийн толгойтой
Морин хуур өлгөөстэй бий .

Хүлэг сайхан морио
Санаад ирэхийн үедээ
Хуур юугаа бариад
Хөгийг нэг чагнахлаар

Сайхан хүлэг морь минь
Миний дэргэд ирээд
Сарны дор янцгаах
Дуу нь надад дуулддаг юм.

Аяа, миний хүлэг
Эмээлт сайхан морь минь
Алхан эрдэнийн хэлбэртэй

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Хүний анхны жигүүр минь

Амьсгалын тоо дуустал
Чамайгаа би мартахгүй
Алтан дэлхийн хүмүүс
Чамайг бас мартахгүй.
Хүн төрөлхтөн өнөөдөр
Сансар хорвоог эзэмшиж
Хүйлэн их огторгуйд
Суман хөлгөөр дүүлж байна

Хүлэг чиний нуруун дээр
Нисэж анх сураагүй бол
Хөвчит оньсон хөлгөөр
Өнөөдөр яахин нисэх вэ?

Алсын сансарт хүмүүс
Үдлээд өнгөрөх өртөөндөө
Ачит хүлэг морио
Магтаж ярина гэж итгэж байна.

Ач гуч минь хэзээ хойно
Оддын хоорондох зайд
Алхан толгойт мориндоо
Хөшөө босгоно гэж найдаж байна.

1979 он

## САНСРЫН ХӨЛӨГ ДАХИАД Л ХӨӨРНӨ

Сүүн зам тэнгэрт татуулан
Сансрын хөлөг дахиад л хөөрлөө
Гүүн зэлэн дээр хөлд орсон
Монголын иргэн сансарт нислээ.
Яасан сайхан зол заяа вэ?
Ямар их баяр баясгалан бэ?
Монгол түмэн бархархан баярлав.
Морь нь хүртэл шилгээн баясав.
Октябрийн орны гарамгай баатар
Сансрын хөлөг удирдаж явна
Олон улсын найрсаг багийнхан
Нислэгийн программ биелүүлж явна
Цэнхэр номин газар дэлхийг
Аягахан цай уух зуур тойрно.

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Цэлгэр уудам Монгол нутгийг
Гуравхан минут ширтэн өнгөрнө
Гуравхан минут ширтэх хугацаанд
Гучин жил хийх ажил зураглана.
Гучин жилийн бүтээн байгуулалт
Гурван үеийнхэнд жаргал авчирна.

Ард түмэн үүнийг огт андахгүй
Алаг үрсээ дахиад л сансарт илгээнэ.
Сансрын эриний ажил гэж дуусахгүй
Сансрын хөлөг бас дахиад л хөөрнө
Найрамдалт орны сансрын нисэгчид
Нам ард түмнийхээ найдварыг биелүүлж
Эрхэм андынхаа хөлөг дотроос
Эрдэм шинжилгээний нээлттэй ирнэ
Хүнээ сансарт анх илгээж
Хөлгийн цуваag анх хөөргөсөн
Хүчирхэг Зөвлөлтийн ард түмэнд
Хүн төрөлхтөн үүрд баярлана.
Дэлгэо Зөвлөлт гүрэн өнөөдөр
Дэлхий орчмын тойрог замд
Асар их байгууламж цогцлуулахаар
Нүсэр их ажил хийсээр байна.
Ард түмэн үүнийг огт андахгүй
Алаг үрсээ дахиад л сансарт илгээнэ.
Сансрын эриний ажил гэж дуусахгүй
Сансрын хөлөг бас дахиад л хөөрнө.
Гарт барьцгүй сансрыг байтугай
Газрыг анх нээгчдийн гавъяаг мартахгүй
Сансрын огторгуйд хүн анх нэвтэрсэн
Сайхан эринд төрсөндөө би баярлана.
Алсын их сансарт амьдрал эхлүүлсэн
Анхны арван гүрэн улс дотор
Морины л найз гэж нэрлэгдэж байсан
Монгол үндэстэн орсонд бахархана.

1981 он

**БИДНИЙ ХҮСЭЛ**

Төрсөн нутгаа
“ Эх орон “ гэж
бид нэрлэдэг юм.
Түүнээс чухал юм

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Энэ дэлхийд
хаа байна ?
Юу чамд сайхан бэ? гэж
Хэн ч надаас асуухад
- Хамгийн сайхан нь
Амьд явах гэж
Хэлнэ би
- Юу чамд хэрэгтэй вэ? гэж
Хэн ч надаас асуухад
- Хамгийн чухал нь
эх орон гэж
хэлнэ би.
Унасан газар
угаасан ус
эх орныхоо
Хөгжил мандлыг
харах тутам
баясах юм.
Урьдах зорилго
сэтгэл нэгт
нөхдийнхөө
Хөдөлмөр тэмцлийг
үзэх тутам
бахдах юм.
Маргаашийн ажлыг
орон даяар
түрүүлээд хийчихэд
Намуухан шөнө
ээлж ёсоор
өнгөрөх юм.
Намайг бас л
өчигдөр үдчихэв үү
гээд л
Найртай маргааш
нөгөөдрийнхөө ажлыг
зээлдэх юм.
Өдөр шөнө
ингэж хурдсаж
байгааг бодоод
Өнө ирээдүйгээ
үүнтэй холбон
санаж үзэхэд
Олон жилийн
хийх ажлыг
урьдчилан хийвэл
Орон улс маань

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

хичнээн их
хөгжинө гэж санана.
Хүсэл хайрыг
булааж татсан
эх орныхоо
Хүү нь болж
төрсний гавъ яа
юу билээ.
Хүсэлтэй сайхан
ирээдүйнхээ төлөө
шамдахаас өөр
Хүндтэй гавъяа
хаанаас бидэнд
олдох билээ.
Өтлөх насандаа
чандраа тавих
энэ Монгол орноо
Улам хурднаар
мандааж бадруулахыг
би хүсэж байна.
Өрнөж байгаа
энэ цагийнхаа
сайн сайхныг үзэж
Өгөөмөр хөгжлөө
бахдан баясан
харж байхад
Улам л ихийг
бүтээх сэтгэл
аандаа төрөөд
Уян залуу
зүрхний минь цохилт
улам хурдсаж
Хангай модыг
ээрэм талдаа
тарьж ургуулаад
Хот тосгодыг
байгуулахын төлөө
зүрх минь цохилох юм.
Хатан Туулыг
элсэн цөл рүүгээ
татаж урсгаад
Хүрэн тариаг
халиуруулахын төлөө
зүрх минь цохилох юм.
Орхоны хүрхрээг
хазаарлан авч

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

станц байгуулаад
Орон даяар
гэрэлтүүлэхийн төлөө
зүрх минь цохилох юм.
Төрсөн нутгаа
эх орон гэж
бид нэрлэдэг.
Түүндээ зүтгэхээс
эрхэм гавъяа
хаа байна.
Үр ач минь
эхээс мэндлэх
энэ Монгол орноо
Юунаас ч илүү
мандааж бадруулахыг
би хүсч байна.
Ирээдүй хэтийг нь
нөхөдтэйгөө хамт
байгуулалцаж байгаа
Итгэл төгс
иргэний нь нэг
би байна.

1951 он.

Зугаатай сайхан нутгаа чи орхиод
Зоргоор, хүний нутагт юунд тэнэнэ вэ?
Дуу чинь тасраад удсан чамайг
Дурсахаа болиод мартах юм биш биз,

Хангай говь хосолсон сайхан нутгаасаа
Хагацаж удаан тэсэх зүрхтэй хүн үү?
Харин бүүр, үдийн нар шиг жаргалыг үзвэл
Харихаа болиод суурьшихаас ч буцахгүй эр үү?

Үгүй нөхөр минь, харин би эх орондоо
Гэрийн үүднээс будаа түүгч болжмор шиг
Харийн нутгаас эрдмийн үрийг цуглуулж явна.

Гайхамшигт нутгаа бэтгэртэл санасан шүлэг эргэнэ
Гантай жилийн дараах өнтэй зун шиг
Зантай сайжирсан хоолой нь дахин цуурайтна.

## НАМУУН ШӨНИЙН БОДОЛ

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Ойролцоох нэгэн төгөлд
Алтан гургуул жиргэнэ.
Орой дээрх тэнгэрт
Мөнгөн зүйдэл гэрэлтэнэ.

Жийсэн хөлийн өлмийд
Нэлийсэн тал уужирна.
Налайсан шөнийн харанхуйд
Цэлийсэн тэнгис шиг бараантана.

Байгаль дэлхийг харахад
Хүний нутаг танигдана.
Байгаа тэнгэрийг ажихад
Багын таньдаг санагдана.

Гуулин шанага шиг махирлаад
Долоон бурхан дүрээрээ.
Гурван марал гэрэлтээд
Багын нүдэлсэн зүсээрээ.

Дээгүүр цэлийх тэнгэрийн
Зүсний өнгө ижил ч
Доогуур нэлийх газрын
Усны амт нэгэн ч :

Шөнийн бодол дунд
Хүнийх болох нь илэрхий.
Сэрхийн харвах сэтгэлд
Миний нутаг тодорхой.

Зулай битүүрсэн цагаас
Минийх гэсэн болохоор
Зулагтай гутлын мөрөө
Анх гаргасан гэхлээр
Өсөж төрсөн нутгаа
Өо зүрхнээс хайрлалтай,
Өндгөө дарсан бүргэд шиг
Өмөөрөн өмчилж хамгаалалтай.
1956 он

**ШОРОО**

Орчлонд миний атаархаж явдаг
Цорын ганцхан амьтан байдаг юм.

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Олноос гойд сайхан ч амьтан биш,
Жирийн нэгэн шувуу байгаа юм.

Хайрт нутгийн минь алтан шороог
Ходоодон дотроо хадгалж явдаг юм
Хойлогтой би, тийм азтайд нь
Хонзон тавьсан юм шиг атаархаж явдаг юм.

Гэлээ гээд би орчлонд бас л
Ганцхан хойлогийг өрөвдөж явдаг юм.
Үнэнийг хэлэхэд би адилхан
Үнэт тэр шороог биендээ хадгалдаг бол

Монгол нутагтайгаа хамт явдагтаа
Магнай хагартлаа баярлаж явах сан,
Хойлогтой адилхан учрыг нь мэдэхгүй
Хоол эрэн гэлдэрч явахгүй сэн.

## НАРАНЦЭЦЭГ

Нарнаас нүүрээ өдөржин салгалгүй
Наранцэцэг эргэн дагах юм.
Шингээд орохоор нь харсан чигтээ
Шилбэн дээрээ гунин зогсох юм.

Санаа сэтгэл минь өдөржин завгүй
Сайхан эх орноо мөрөөдөх юм.
Зөвхөн шөнөдөөн амравч тавгүй
Зүүдэн дундаа хамт байх юм.

1957 он
Переделкино тосгон

## НИСЭЭД ИРСЭН ШУВУУ ШИГ

Нисээд ирсэн шувуу шиг
Тэнгисийн эрэгт би сууна.
Нүргэлээд байгаа тэнгэо шиг
Долгисын шуугиан хүржигнэнэ.
Хэрмэн уулс хүрээлээд
Крым нутаг гоёхон байна.
Хэрэггүй шахуу гэгэлзээд

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Хүний сэтгэл туяхан юм.
Элэнц хуланцын өвгүүд минь
Энд нутагтай байсан юм.
Үзэсгэлэнт энэ нутгийг
Удаж суурьшилгүй орхисон юм.
Нүүгээд явсан буурийг нь
Эргэж үзэхээр ирсэн шиг
Нүцгэн цохионы орой дээр
Энд би сууна.
Ганганаад зэллэсэн шувуу шиг
Өвгөд минь эндээс нүүсэн юм.
Газрын холхи талыг
Үүрдийн нутаг гэж муусан юм.
Холоос ирсэн шувуу шиг
Маргааш би буцна.
Хумсанд шороо нь шингэсэн
Монгол орондоо харина.
Зэлүүд байхад нь өвгүүд минь
Шаваа манд босгосон юм
Залгаж уламжлаад бид
Эх орноо гэж өргөмжилсөн юм.

1959 он.
Крым

## ЭХ ОРОН ИРГЭН ХОЁР

Харийн сайхан нутагт
Насны хэсгийг элээхдээ
Хайрт эх орноо би
Сэтгэлдээ дааж явлаа.

Гэгээн сайхан Эх орноо
Дааж яваа хөлийн минь доор
Гишгэгдсэн газрын нуруу
Нахис хотос хийх шиг байлаа.

Эх орон иргэндээ
Эр чадлыг шингээдэг юм
Грек орон байгаагүй бол
Геркулес төрөхгүй байсан юм.

Эх орноо иргэн нь
Сэтгэлдээ дааж явдаг юм.

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Эх орон нь иргэнээ
Элгэн дээрээ тээж байдаг юм.

Удаан хугацаагаар харийн холд суухын цагт
Уушги зүрхээ шаналтал Эх орноо санах хэцүү.
Тэгэвч эргээд нутгийн хилийг алхахын үед
Тэнгэр цэлмэх шиг сэтгэл зүрх уужрах сайхан.

1959 он.

## ЭХ ОРОНДОО ЭГЖ ИРЭХҮЙ

Удаан жилийн жуулчлал маань дуусаж
Уугуул нутгийнхаа хил дээр ирэв.
Халх нутгийнхаа шороог шороог үнэртвэл
Хайрт хүүхний минь үнэр ханхлав.

Даан удалгүй гэртээ ирэхэд
Даамай амраг минь угтан золгов.
Хайрт хүүхнийхээ духан дээр үнсвэл
Халх нутгийн минь шороо ханхлав.

1959 он.

## МИНИЙ АРАНШИН

Хөхөөн дууны ногоохон зунаар
Хөвч хангайнхаа зусланд байхдаа
Хавтгайн чөмөг царцам өвлөө
Харахсан гэж хүсдэг шигээ би,
Цэцэгт хангайдаа давхиж явахдаа
Цэнхэрхэн говьдоо очихсон гэж яарах юм.

Буурын шүдний хангинах өвлөөр
Бударганат говийнхоо өвөлжөөнд байхдаа
Хандгай аяндаа хөлрөм зунаа
Харахсан гэж хүсдэг шигээ би
Алтан говьдоо давхиж явахдаа
Аглагхан хангайдаа очихсон гэж яарах юм.

Цэнхэр хаврын нүдлэх хавраар
Цэлгэрхэн талынхаа хаваржаанд байхдаа

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Өнчин янзага өөхлөх намраа
Үзэхсэн гэж хүсдэг шигээ би,
Цайдам талдаа давхиж явахдаа

Цастайхан ууландаа очихсон гэж яарах юм.

Халиун буганы урамдах намраар
Хан уулынхаа намаржаанд байхдаа
Ууган төл цангинах хавраа
Үзэхсэн гэж хүсдэг шигээ би,
Үүл шүргэсэн ууланд явахдаа
Өргөнхөн талдаа очихсон гэж яарах юм.

Энэ бүхэн миний араншин
Эцэг эхээс өвлөсөн араншин
Өвөл, зун, хавар, намаргүй
Уул, тал, хангай, говьгүй
Тийм нутагт сэтгэл минь тогтохгүй,
Тэгээд ч би амьдарч чадахгүй.

1968 он

## ЭХ ОРОН

Миний хайрт эх ороон
Мөөгний хүрээ шиг цүдгэр гэдэстэй
Малчин эх чамайг анх
Малынхаа бэлчээр дээр нярайлсан байнам.

Алтан дэлхийн энээхэн чөлөөнд
Анх мэндэлж эхээс төрөхөд чинь
Илгэн дээлтэй морьтон хүдэр эр
Эх барьж чамайг гардан авчээ.

Нутаг усаараа тэднийд цуглаж
Нугын зүлгэн дээр гэр барьж
Магнай тэнийн угаалгыг чинь хийж
“ Монгол орон” гэж чамайг нэрлэжээ.

Зүрхний хайрт эх орон чи минь
Зүйдэлт тэнгэрийн дор анх ингэж
Монгол гэдэг дотнохон нэрээр
Морьтон ардтай заяа холбожээ.

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Морьтон ард минь түүнээс хойш
Морин дэл дээр сүлдийг чинь тахиж
Өндгөө дарсан уулын бүргэд шиг
Үеийн үед чамайгаа хайрлажээ.

1968 он.

## УССУР МӨРӨН ДЭЭР БОДСОН БОДОЛ

Даманскийн хилчин
Лениний одонт
В.М.Каныгинд
Зориулав.
Уссур мөрний урсгал сөрөн
Онгоц хөвнөм
Өнөр Зөвлөлтийн хил даган
Бид хөвнөм

Усархаг Уссурийн хоёр эрэг
Хоёр гүрнийх
Ургалд нь аялагч бид нар гэдэг
Өөр орных

Торолзон хурдлах хуягт хүлэг
Хилийн цэргийнх
Торгон хилдээ аялуулна гэдэг
Хуруу шигээ итгэснийх

Даманскийн баатруудтай уулзана гэхээс
Зүрх догдолно.
Дайчин үйлсийг нь яриулна гэхээс
Сэтгэл яарна.

Хүлгийн өвчүүнд мөрний урсгал
Ярагдан үлдэнэ
Хүрэхээр зорьсон Дамансх арал
Ойртон ойртоно

Өөрийн эрхгүй гүн бодол
Намайг дарав
Өнгөрсөн тулааны үйл явдал
Нүдэнд харагдав

Итгэлийн өөдөөс хятад хүн

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Буу шагайв
Эрчилсэн хилэнг бууны дуун
Өөртөө татав

Цэрэг эрсийн цэнэгтэй буу
Сүүлдээ хайлав
Цэлгэр оросын хилчдийн суу
Нэлдээ дуурсав

Холын замд би алдаг оног
Ийнхүү бодов
“Хормой дор дайсан бий”гэдэг
Үг санагдав.

Хуягт онгоц урсгал сөрөн
Улам довтлов
Хувь заяа нэгтэй нутагтаа хандан
Ингэж шивнэв:

Эр орон иргэнээ нэг л цагт
Шалгадаг байнам
Иргэний чанар тэр л үед
Танигддаг байнам.

Энхрий монгол орон!Би чамдаа
Мөнх данстай
Иргэн намайгаа хэрэгтэй цагтаа
Заавал шалгаарай

1969
Уссур мөрөн

**Эх орондоо**

Алтан дэлхийд анх ирээд
Алгын чинээ өлгийд багтаад
Аав нэрийг минь өгөөгүй байхад
Айлдаа дуу минь хүрээгүй байхад
Сэвлэг хархан шингэн даахийг минь
Сэвэлзэх салхиараа хатааж өгсөн
Өлгий нутаг эх орон чамдаа
Өр зүрх үнэн голоосоо би хайртай

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Өсөх бие эрийн цээнд хүрээд
Өрх гэрийн амьдрал толгойлоод
Үрээ өсгөх гэж мэрийж байхад
Үйлсээ дэвжээх гэж чармайж явахад
Магнай хагартал данадаа баярлуулж
Тагнай өөхөлтөл жаргал эдлүүлсэн
Өлгий нутаг эр орон чамдаа
Өр зүрх үнэн голоосоо би хайртай

Цаст уул шиг тэргүүн минь цайгаад
Цагийн эргэлтэнд тэнхэл минь сульдаад
Ээлжит хорвоогийн жам ирхэд
Эхэлсэн дуугаа дуусгалгүй орхиход
Алд биеийг минь хөрсөн гэлгүй
Алтан хэвлийдээ шингээн авах
Өлгий нутаг эх орон чамдаа
Өр зүрх үнэн голоосоо би хайртай.

1971 он.

**Эх ороны тухай дуу**

Агийн цэнхэр утаа шиг
Уул талгүй униартай
Алганы танил хээ шиг
Ухаан санаанд тодорхой
Энхрий монгол орон минь
Чамдаа би хайртай
Энэхэн яваа насандаа
Сэтгэл зүрхээрээ чиний
Үд дунлын тэнгэр шиг
Өргөн болоод саруулхан
Үнэн голын яриа шиг
Өр зүрхэнд дотнохон
Энхрий Монгол орон минь
Чамдаа би хайртай
Энэхэн яваа насандаа
Сэтгэл зүрхээрээ чиний
Уулын оргил цастай ч
Үүлний сүүдэр дулаахан
Усны харз нь хүйтэн ч
Ундаа болох нь бүлээхэн
Энхрий Монгол орон минь
Чамдаа би хайртай
Энэхэн яваа насандаа
Сэтгэл зүрхээрээ чиний

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Алиман сарны толио шиг
Бүхий олон эндахгүй
Алтан нарны туяа шиг
Бид хэзээ ч салахгүй
Энхрий Монгол орон минь
Чамдаа би хайртай
Энэхэн яваа насандаа
Сэтгэл зүрхээрээ чинийх.

1971 он.

**Зөвхөн Монголдоо**

Цэцгийн сайхныг би зөвхөн нугаасаа түүлээ
Цэнгэлийн дууныг би зөвхөн талаасаа сонслоо
Хүлгийн хурдныг би зөвхөн сүргээсээ барилаа
Хүүхний царайлагийг би зөвхөн Монголдоо харлаа

Усны тунгалагийш би зөвхөн уулнаасаа амслаа
Ухааны саруулыг би зөвхөн өвгөдөөсөө өвлөлөө
Андын журмыг би зөвхөн ардаасаа сурлаа
Амьдын жаргалыг би зөвхөн Монголдоо эдэллээ.

1973 он.

**Цаг ирлээ ч гэсэн би үхэхгүй**

Цаг ирлээ ч гэсэн би үхэхгүй
Цогцос чандар булагдах нь хамаагүй
Харин би цэлмэг тэнгэрийнхээ
Хаа нэг зайд нь од болон хувирна

Ухаант амраг минь хойноос очиж
Удалгүй тэр од хоёул болно
Хоёулаа болоод өндөр тэнгэрээс
Хонгор нутгаа хайрла н ширтэнэ.

Сайхан эр орон минь тайван байвал
Санаа сэтгэл минь амгалан байна
Шинэ сэргэг бүхэнд нь баярлаж
Шөнийн харанхуйд инээмсэглэн гэрэлтэнэ.

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Хэрвээ Эх оронд минь гай учирвал
Хэрхэвч би тэнгэрт гэрэлтэхгүй
Хүйтэн огторгуйд амрагаа орхиод
Хүй минь булаасатай нутгаа тэмцэнэ.

Тэсэж ядсан хилэндээ шатаад
Тэнгэрийн солир болж газарт бууна
Тэрслэх дайсны үүрэн дээр унаж
Тэр чигээр нь үнс болгоно.

Сайхан өлгий нутгаа аварсан
Солирын талст минь газарт гэрэлтэнэ
Амьддаа төлөлгүй орхисон өрөө
Ард түмэндээ ингэж төлнө.

Эх орны тухай дуу

Уулын оройг нь уудлах юм бол
Туждаа есөн эрдэнэтэй
Удам талыг нь сөхөх юм бол
Тунгалаг усан тэнгистэй
Алтан тариа нь
Дөрвөн далайн давалгаатай
Арвин сүрэг нь
Таван тивийн шагшаатай
Цэцэгт дэлхийн магнай
Цэлмэг тэнгэрийн өлгий
Энэхэн хорвоод ганцхан
Эзэн бидэндээ сүжхэн
Монгол орон жаргалтай
Монгол хүн заяатай
Хүний сайхныг нь хэлэх юм бол
Хангайн нуруу шиг гүндүүгүй
Хүлгийн хурдныг нь жиших юм бол
Хунгийн далавч гүйцэхээргүй
Үдшийн бүрий нь
Яралзсан хотын гэгээтэй
Үүрийн туяа нь
Янагийн сайхан инээвхийлэлтэй
Цэцэгт дэлхийн магнай
Цэлмэг тэнгэрийн өлгий
Энэхэн хорвоод ганцхан
Эзэн бидэндээ сүжхэн
Монгол орон жаргалтай
Монгол хүн заяатай
Намын ачийг нь ярих юм бол

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Зуны нар шиг энэрэлтэй
Найзын чанарыг нь хэлэх юм бол
Зузаан эвийн гагнаатай
Урагшлах зам нь
Таван жилийн алхаатай
Угтах ирээдүй нь
Арван нарны туяатай
Цэцэгт дэлхийн магнай
Цэлмэг тэнгэрийн өлгий
Энэхэн хорвоод ганцхан
Эзэн бидэндээ сүжхэн
Монгол орон жаргалтай
Монгол хүн заяатай

**Эх орны өглөө**

Үүриин өмнөхөн бороо ороод
Үүлээ хөөж тэнгэр цэлмэсэн
Эх орны минь тунгалаг өглөө
Энхрий янагийн минь царай шиг сайхан

Унтаад сэрэхэд санаад босдог
Улаанбаатарынхаа өргөн гудамжинд
Ургах нарнаар алхаж явахад
Урам сэргээд өөдрөг сайхан

Нойтон навчис шил шиг гялтганаж
Норсон болжмор мөчир дамжиж
Хөөрөх наран илчээ нэмээд
Хөлийн дороос уур савсана

Зөрсөн хүмүүс цөм танимхайрч
Зүг болгон мэндээ мэдэлцэж
Өглөөний аггарт хөл нь хөнгөрөөд
Өөрсдийнхөө ажилд эртлэн алхацгаана

Өндөр настанууд урьдыг бодвол
Өтөл овор суугаагүй явцгаана
Үр ач нар маань ихэр юм шиг
Үзэсгэлэн гоо төрсөн харагдана

Шинэ өдрийн тунгалагхан өглөө
Шимт дэлхий туждаа нялхарч
Орчлонд жаргасан олны дунд явахад

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Олон насаар өөрөө залуужна

Найлзуур бүхэн нь багсайн цэцэглэж
Намиран байгаа моносыг хараад
Амьдрал заяагаа зүйрлэн хайрлаж
Алаг зүрх минь баярлан оволзоно

Энэ сайхан хүмүүсийн дунд
Энхрий орныхоо хайраар жигүүрлэж
Умбан нисч яваа хараацай би
Урт наслахгүй яахав гэж бодогдоно

Аз заяандаа сэтгэл минь дэвэрч
Авааль гэргийдээ дахин дурлаж
Өөрийгөө өвчсөн үрийгээ байтугай
Өрөөл бусдыг ч үнсмээр санагдана

Нойтон навчис шил шиг гялтганаж
Норсон болжмор мөчир дамжиж
Хөөрөх наран илчээ нэмээд
Хүн болгон ажилдаа алхсан

Энхрий янагийн царай шиг сайхан
Эх орны мин ь өглөө бүхэн
Унтаад сэрэхэд санаад босдог
Улаанбаатарын минь өглөөгөөр эхэлдэг.

1978 он.

**Үеийнхэндээ**

Элгэн халуун эх ор он минь
Энх тайван цэцглэж
Хүн ардынхаа хөдөлмөрөөр
Хүрэх ирээдүй нь ойртож
Эрх жаргалын нар мандсан
Энэ сайхан үед
Өөрөө анзаарч мэдэлгүй явтал
Өчүүхэн бие минь өтөлнө гэдэг
Өөрийн биеэрээ бид
Жаргал эдэлж яваагийн тэмдэг!

Элгэн халуун ард түмэн минь
Энх төвшин жаргаж

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Ариун цагаан хөдөлмөрөөр
Айл бүхэн дэвжиж
Эрх чөлөөний нар мандсан
Энэ сайхан үед
Өөрөө анзаарч мэдэлгүй явтал
Өтгөн үс минь цайна гэдэг
Өргөн түмэндээ бид
Тус хүргэж яваагийн тэмдэг!

Эрдэнэт хүн алтан амиараа
Эх орноо үнэлдэг болохоор
Хүний эх орон шиг үнэтэй юм
Хүж дэлхийд үгүй юм

Өлгий нутгаа найраг шүлэгчид
Өр зүрхнээсээ дуулдаг болохоор
Дуулал найраг шиг үнэтэй юм
Дули хорвоод ховор юм

## Монгол орон

Ази тивийн аварга мөрдийг
Арван тийш нь урсгаж байдаг
Их газрын нэгэн өндөрлөг дээр
Эх орон минь цэлийн байна

Эх орны энэ өндөрлөгөөс
Эргэн тойроныг харахад саруул
Холын бараа эндээс тодхон
Хотол дэлхий үнэхээр уужуу

Энд ухаант хүний бие эрүүл
Эгшиглэх дууных нь ая яруу
Цэнхэр байцын цуурай чанга
Цээжинд орох агаар цэнгэг

Эмээлт морины туурай цомбон
Эзэн хүний зориг нь шулуун
Тураг шувуудын далавч нь урт
Тунарах тэнгэрийн өнгө цэнхэр

Уулын орой мөнх цастай
Урсгал ус нь өвөл харзтай
Манхан хадны сарлаг сүртэй

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Мал нь хүртэл өндөрт дуртай

Тэнгэрийн од энд олон
Тэртээ гариг эндээс ойрхон
Он жил нь дөрвөн улиралтай
Хүн ард нь түүндээ дуртай

Үдший н дараа саран мэлмэрч
Үүрийн дараа наран тунарч
Их газрын нэгэн өндөрлөг дээр
Э х орон минь цэлйин байна

**Хадлан**

Намрын хурц нарны туяанд
Навч цэцэг халиурч байна
Сэвэлзэн үлэээх сэрүүн салхинд
Сахлаг хадлан шуурайлж байна

Халуун хайрт нөхдийн хамт
Халиурсан хадлангаа хадаж байна
Хайрыг улаасан хүү минь
Хамуурдан бухалдан хурааж байна

Тавлан нуруулдсан үрлэг бухлууд
Давхар барилга шиг сүндэрлэж байна
Хадлангаа бэлтгэсэн бидний баясал
Түүнээс илүү бадарч байна

Цан хүүргээ шашин үлээсэн
Царцам өвөл ирэхэд ч тэр
Хахир хатуу догшин амьсгалт
Хаврын агааар ирсэн ч тэр

Хамаг мал нь дулаан хашаанд
Халуун өвсөө тайван иднэ
Хүчээ гаргаж хөдөлмөрлөсөн бид
Хөөр хуучаа тавтай ярилцана

Мал минь тарган учраас
Төл минь бүрэн бойжно
Сүрэг минь өсөх тутам
Зориг минь улам нэмэгдэнэ.

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

1949 он.

**Тээврийн жолоочийн дуу**

Тал шиг тэвш нь дүүрэн бараатай
Тээврийн машин хүнгэнэн довтолно
Гал шиг сэтгэл нь дүрэлзсэн баяртай
Хээрийн замд жолооч уралдана

Довтлогч тэрэгнийх нь дугуйн дор
Тунгалаг наран гэрлээ дэвсэж
Алс аяны алтан замд
Амжилт ерөөн уулс мэндэлнэ

Нүүгэлтсэн тал өмнө нь цэлийгээд
Нүүсэн тоос хойно нь хоцорно
Уралдаант ажилдаа урам нь сэргээд
Уянгын дуугаа жолооч аялна.

Довтлогч тэрэгнийх нь дугуйн дор
Тунгалаг наран гэрлээ дэвсэж
Алс аяны алтан замд
Амжилт хүсэн гүүрүүд бөхийнө

Өргөн талыг сум шиг зүсээд

Өндөр уулыг шувуу шиг даваад
Амласан газартаа саадгүй хүрэхэд
Ачих бараа нь уул шиг хүлээнэ

Довтлогч тэрэгнийх нь дугуйн дор
Тунгалаг наран гэрлээ дэвсэж
Алс аяны алтан замд
Анд нөхөд нь угтан мэндлэнэ.

1952 он.

**Ус ирлээ**

Хааяа хааяа
Овгор товгор

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Замыг дагаад

Байн байн
Боргио давалгаа
үүсгэсээр
Шугам татсан
Цэнхэр ус
Сувгаа дүүргээд
Шуугиад айсуй . . .
- найз нар минь
Ус ирлээ.
Эрэг дээр нь
Зогсож байгаа
хүүхэн инээлээ.
Энгэр дээр нь
алтан од
гялалзаж байлаа
Цэлэлзсэн ус
хүүхний дэргэдүүр
шуугин гарахад
Цангинасан дуугаар
баяртай гээд
үдэж байлаа
Гал улаан тугууд
сувгийн боомтоор
дэрвэлзэнэ
Голын эргийн дагуу
цугласан хүмүүс
бахархана
Зөвлөлтийн хүний
гараар бүтсэн
тэнгисийн сав руу
Дөлгөөн Доны
тунгалаг ус
цутгаад орлоо.

Галтай хөдөлмөрөөр
байгалийн алдаа
засагдаж
Газрын зурагт
нэмэгдэж байгаа
тэнгисээ хараад
Идрийн галаар
хүчээ сэлбэж
барьсан ээзд нь
-Ирээдүй –коммунизм !

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Эрх чөлөө-
Энх тайван! гэлээ.
Алга ташилт
тэнгисийн мандалаар
цуурайтаад ирлээ
Ариун Ижил
намуухан Дон
мөнх нийллээ.
Балчир охин нь
эцгээ хүзүүдээд
тэнгисийн ус
Хаачих нь вэ? гэж
гайхан асуулаа.
Буурал эцэг
ачийгаа тэврээд
-Дон мөрөн
ижил мөрөнтэйгээ
золгож байна гэлээ.

1952 он.

## Сонин сурвалжлагчид ярьсан нь

Үнэндээ сурвалжлагч ажилчин хоёр дотно байдаг нь
Үзтэл тодорхой байхыг хэн эс андах вэ?
Социалист уралдааны явцад шинээр юу гарав гээд л
Сонин сурвалжлагч үйлдвэр рүү хүрээд ирлээ
Орох зөвшөөрөл авч мэнд мэдчихээд сурвалжлагч
-Оройлж ямар ажилчин уралдаанд шалгарч байгааг
Онцолж юун дээр шинэ санаачлага гарч байгааг
Орхилгүй ярина уу?гэж үйлдвэрийн даргаас хүслээ
Олон ажилчдаа арван хуруу шигээ сайн мэддэг
Оргилоод гарсан шинэ санаачлагыг дэмжиж байдаг
Олон ч жил үйлдвэрийг удирдсан хижээл хар хүн
Улирал сарынхаа дүнг дэлгээд ингэж хариуллаа
-Өнгөрсөн сард үйлдвэрийн төлөвлөгөө 200% биелсэн
Өрнөж гарсан шинэ санаачлага маань нийтэд дэлгэрсэн
Уралдаанyхаа тугийг хэнд ч бид алдахгүй гэлээ
Уралдаж одоо стахановч туршлагааар ажиллаж байна гэлээ
Удам сайхан монгол орны минь хязгаар бүрд
Улсын аж ахуй уурхай үйлдвэрүүд байгуулагдаж
байна.
Улиг болсон ажлын хуучин нормыг шинэ хүмүүс эвдэж
Улс орныхоо төлөө хүчээ нэгтгэн хөдөлмөрлөж байна

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Сурвалжлагч хүний ажил явах бичих л болсон хойно
Сурвалжлагч маань Чоногол Бүрэнцогт руу очлоо
Уурхайчдын өрөм газрын гүнд зэрэг уралдаж
Өнгөт металл хар алтыг вагаон вагоноор гарагж байна
-Уурхайд ороход биднийг уурхайчны дэн минь
гийгүүлдэг юм
Уралдаж ажиллахад биднийг намын уриа зоригжуулдаг
юм гэж
Эвлэлийн бригадын дарга залуухан эр бахдан ярилаа
Эндээс яваад сурвалжлагч улсын аж ахуй руу очлоо
Удам саруул талд өнгөрсөн жил байгуулсан
Улсын аж ахуйн дараг түүнийг хүлээж аваад
-За Сурвалжлагч чухам ямар ажилтай танилцах вэ?
Залуучуудын бригад уу?бүх аж ахуйгаар нь уу?
Аж ахуй маань ч өдрөөс өдөрт л өргөжиж байна
Ардын засагч хайр ивээлээ харамгүй өгч байна
Мал өсгөх ажилдаа бид Зөвлөлтийн туршлагыг хэрэглэсэн
Манай аж ахуй шинэ үүлдэрийн малтай болно
Тэгэхээр та бас л үүгээр зочилж ирээрэй гэж
Талын монгол хүний зочломтгой зангаар үдлээ
Буцах замдаа сурвалжлагч ардын нэгдлээр орлоо
Буурал өвгөн нэгдэлийн дараг ингэж хэллээ
-Өнгөрсөн үеийн зовлонд үс минь буурал суусан ч
Өнөөгийн засгийн халамжинд амьдрал маань залуужиж байна
Өвгөдийн үеэс нутагшсан бидний эх оронд
Өнөр сайхан социализмын нарлаг үүр цайж байна

**Уул уурхайн тухай шүлгүүд**

1.Уурхайн замд

За нөхөр минь их хотоос замд гарахад
Заавал саатдаг нь үнэн юм даа.Цагаа хараач ?
-Эрхэм минь битгий зов.Унаа маань хурдан шүү дээ
Их л хождохдоо уурхайд шөнөдсхийгээд хүрнэ биз дээ
Нөхөр маань энэ үгийг дуулаад толгой дохилоо
-Нээрээ л тийм дээ .Замд маань саад байх биш гэлээ
Наргианч нөхөр маань тамхиа гаргаж биднийг дайллаа
Намхан хамраараа утаа савсуулж алсыг ширтлээ
Идэрхэн жолооч маань залуураа чадамгай мушгина
Эрчилсэн дээс шиг урдах зам эрээлжлэн үзэгдэнэ
Өвсөн толгой ёслон үдэх шиг бөхөлзөн хоцроно
Өндөр уулс тосон авах шиг сүндэрлэн угтана
Урьд өмнө би үүгээр овоо хэд явсан юм

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Удам их хорвоогоор хэрэн жуулчлах дуртай юм.
Явж өнгөрсөн газартаа хожим эргээд очиход
Яахын аргагүй хүний хөдөлмөр цэцэглэсэн байдаг юм.

Ээрэм талд мал сүрэг багширч харагдлаа,
Эзгүй хээр шинэ тосгон боссон үзэгдэнэ.
Эртний үлгэр домогт гардаг лусын эзэн гэдэг
Ээ дээ ард түмнийг л хэлсэн үг байх даг шүү.

Идэрхэн жолооч маань залуураа чадамгай мушгина.
Эрчилсэн дээс шиг урдах зам эрээлжлэн үзэгдэнэ.
Өвсөн толгой ёслон үдэх шиг бөхөлзөн хоцроно.
Өндөр уулс тосон авах шиг сүндэрлэн угтана.

- Хүүе, нөхөр минь чи тэртээ тийшээ хараач,
Хөвөрсөн урт вагоны довтолж яваag үзээч
Наана нь яваа тэмээн жингийн цуваag хараач
Намбатай удаан урагшилж яваag ажиглаач.

- Эрхэм минь, энэ чинь үнэндээ тэмээ вагон
хоёр ч гэсэн
Эргэцүүлж сайн бодвол юманд учир бий шүү дээ
Яах аргагүй л манай өчигдөр өнөөдөр хоёр
Яг үнэн дүрээрээ, нүдэнд тусах нь энэ шүү дээ

Идэрхэн жолооч маань залуураа чадамгай мушгина.
Эрчилсэн дээс шиг урдах зам эрээлжлэн үзэгдэнэ.
Өвсөн толгой ёслон үдэх шиг бөхөлзөн хоцроно.
Өндөр уулс тосон авах шиг сүндэрлэн угтана.

Зорьсон газартаа ойртох тусам бид яараад
Цогцлон боссон үйлдвэрийг үзэхсэн гэж сэтгэл хөдлөөд
Жолооч бид гурав үлгэрийн баатар шиг хурдлав.
Зуны тэнгэрт од цэцэглэн ярайв.
- За ингэхэд та нар чинь, уулын үйлдвэр
байгуулсанаас хойш
Замын хүзүүг тийш нь залаагүй юмуу гэж жолооч хэлээд
Тэнгэрийн од газарт харагдвал хүрлээ гэж бодоорой гэлээ.
Тэнэгэр талд гэрэл үзэгдвэл очлоо гэж санаарай гэлээ.

Идэрхэн жолооч маань залуураа чадамгай мушгина.
Эрчилсэн дээс шиг урдах зам хөврөн үзэгдэнэ.
Өвсөн толгой ёслон үдэх шиг бөхөлзөн хоцроно.
Өндөр уулс тосон авах шиг сүндэрлэн угтана.

Од хэдийн түгээд шөнө дөл болсон хойно

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Огцомхон уулын суга өөд машин маань хурдаллаа.
Зуны сайхан шөнийн тогтуун тэнгэрт
Зургар хөмсгөн саран мэлмэрч байгаа харагдлаа.

- За жолооч минь дөхөж явна уу? гэж би асуулаа.
- За даа юу юугүй л шахаж явна гэж жолооч хэллээ.
Ариухан салхи сэвэлзсэн хөдөө хээрийн энэ шөнө
Аяндаа өөрөө засагдсан зам аяллын чигийг заллаа.

Идэрхэн жолооч маань залуураа чадамгай мушгина.
Эрчилсэн дээс шиг урдах зам гэрэлд эрээлжилнэ.
Ашгүй нэг , газар дээр гэрэл гэгээ яралзан харагдлаа.
Ай даа өнөөх, уулын уурхай гэдэг маань энэ бий.

## 2. ЭРДЭНИЙН УРСГАЛ

Уурхайн хотод ирсэний хэрэг юу билээ
Үйлдвэр заводын нь дотуур орож үзье гэж
Уулын бэлд хэвтэж байсан баялгийг ашиглаж
Үнэт металл ялгаж авахыг нь харья гэж

Үүр, уулын цаанаас цайх гээд гэгээрч байхад
Үзэсгэлэнт зуны өглөө эхлэх дөхөж байхад
Унаа улаалж явсаар уулын үйлдвэр лүү очлоо
Улаавтар шороог тэнд уул шиг овоолсон байлаа.

Уулын хөрсний нэгэн төрөл шороог онгилж
Ус, цахилгаан, техникийн хүчээр угааж
Алтнаас үнэтэй ховор эрдэнийн баялгийг
Арвин эхээр ялган авч байгааг харахад

Уулын үйлдвэрийг анх үзэж байгаа надад
Ухаан санаанд багтмааргүй юм шиг байвч
Хүний хөдөлмөр юуг ч дийлдэгт итгэсэн
Хүрэн зүрх минь баяраар халгин цохилов.

Анхны дамжлагаар орсон өнөөх шороог
Арав гаруй дамжлагаар угаагаад ирэхийг нь харлаа.
Үерийн горхи асгат уулнаас бууж байх шиг
Эрдэнийн урсгал урсаж байхыг нь үзлээ.

Суурь машины хүнгэнэх дуунд чих дөжрөөд
Сурч эзэмшсэн уурхайчдыг харж сэтгэл хөдлөөд
Шөнө болдоггүй үйлдвэрийн дотуур хэрэн хэсэж

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Шижигнэсэн залуу уурхайчдын дунд амьдарч явахад

“ Уухай, ингэ, тэг “ гээд л өдөр шөнөгүй
Уулын уурхайчдад зөвлөж явдаг орос инженер
Эрхийн чинээ гялтгар хар чулуу шиг юм үзүүлээд
- Ээ, нукур, энэ эрдэнэ. Гэж над хэллээ.

## 3. УЛААН ДАРЦАГ

Үүрийн хяраанаар би уулын үйлдвэр оров
Үйлдвэр завод туждаа нүргэн хүргэн ажиллаж байв.
Уулын хүрэн бүргэдэрхүү хүдэр эрийн гарын доор
Уул хад шиг бараатай суурь машин хүнгэнэж байв.
Уулын хүрэн бүргэдэрхүү хүдэр эрийн дэргэд
Уралдааны улаан дарцаг гал адил намирч байв.

Үдийн нарнаар би уулын үйлдвэрээр оров.
Үйлдвэр завод туждаа нүргэн хүргэн ажиллаж байв.
Үүрийн цагаан цолмонорхуу сайхан бүсгүйн гар дор
Үлэмжийн хорвоод ховорхон эрдэнэ гэдэг савлагдаж байв.

Үүрийн цагаан цолмонорхуу сайхан бүсгүйн дэргэд
Үзэсгэлэнт улаан дарцаг гал адил намирч байв.
Үдшийн бүрийгээр би уулын үйлдвэрээр оров.
Үйлдвэр завод туждаа нүргэн хүргэн ажиллаж байв.
Галбын шаргал талархуу ханхар залуугийн гарын доор
Гайхамшигийн дээд гэмээр бүхэл завод нүргэлж байв.
Галбын шаргал талархуу ханхар залуугийн дэргэд
Гал улаан дарцаг дөл адил намирч байв.
Уулыг зөөх чадалархуу ажилчин хүний дэргэдээс
Уралдааэы улаан дарцаг ихэр юм шиг салахгүй байв.

## 4. ХУУЧИН ТАНИЛ

Ижил ижил байшин эгнүүлэн зэрэгцүүлж бариад
Эгц эгц гудамжууд ийш тийш нь засаад
Хоёр талаар нь залуухан мод жирийтэл нь тарьсан
Хөнжиж байгаа уурхайн тосгонд би очлоо.

- Сайн байна уу? гэж хажуугаас хүн мэндэллээ.
Сайтар ажиглаж харвал багын танил маань байлаа.
Унаган нутгийн бид хоёр, хэзээ хойно, энд
Уулзаж нүүр учирснаа ховор олз шаалаа.

Олон жилийн тэртээсэн, Сайн санаж байна би,
Одоо бодход саяхансан, Бид хоёр гэдэг

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Хээрийн нэгэн бэлчээр дээр нудрага зангидан уулзсан юм.
Хэзээ хойно ингэж уулзана гэж зүүдлээгүй юм.

Өнчин хөх ишгийг манайх танайх гэж булаацалдаад
Өдөржин хоёул маргалдаж энгэр заамаа уралцсан юм.
Өвөг дээдсийн үеэс өвлөж ирсэн хөрөнгө
Өөрийн эрхгүй бид хоёрыг нудрага зангидахад хүргэсэн юм.

Гэтэл одоо нөхөр маань уулын уурхайч болоод
Гэрэлт сайхан орныхоо ирээдүйг барилцаж яваа гэнэ.
Гэлээ ч гэсэн би яруу найрагч болоод
Гэгээн ажилчин ангийнхаа сүр жавхааг дуулж сууна.

Эх хүн өсөж, эсгий сунадаг болхоор
Эдүгээ бид хоёр хэн хэн нь байргашжээ.
Эргэх цагийн аясыг тэнэг харанхуй дагасангүй
Эрхий хуруу шигээ итгэсэн нэгэн үзэлд нэгджээ.

- За найз минь чи залуучуудын байраар ор,
- Зантай сайхан амьдарч байгааг нь үз гэж
- Шинэ мөртөө хуучин танил минь намайг дагуулж
- Шил толь шиг гялалзсан нийтийн байраар орлоо.

Шинэхэн будгийн үнэр ханхийн сэнгэнээд
Шилэн гэгээвч болгон дээо тарималцэцэг алаглалаа.
Тэндээ л нэг тохилог сууц байрыг нь үзээд
Тэртээ дээр үеийн минь оюутны амьдрал санагдлаа.

Багын танил нөхөр минь над руу нэг хараад
Баяртай xархан нүдээрээ дотно гэгч инээмсэглээд
- Ажилчин бид иймл сайхан амьдарч байгаа юм шүү,
Ачит нам, засгийн минь хайр халамж юм шүү.

Энэ байранд дандаа залуу ажилчид сууж
Эвтэй гэгч нь аргагүй нэг гэр бүлд амьдардаг юм.
Гэм нь гэвэл одоохондоо гэрлэсэн хүн цөөхөн юм.
Гэхдээ л манай тосгонд хурим тасардаггүй юм гэлээ.

5. УУРХАЙН ХОТ

Тэнд би зочид буудлын тагт дээр гарлаа.
Тэр хотыг үзээгүй нүдээр ажиглаж харлаа.
Тэрхэн зуур хотын гэрэл яралзан аслаа,
Тэнгэрийн од буугаад ирэх шиг над үзэгдлээ.

Дэврэн хөөрсөн сэтгэл зүрхнээс болоод ч тэр үү

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Дэгж дэрвэх хүүхэд адил баяслаа.
Одот тэнгэрийн доорхи уурхайн хотыг ажихад
Орчлонд нэг цэцэг цоморлигоо дэлгэх шиг санагдлаа.

Холын холд аврага том механизм хүнгэнээд
Хотын гэрэл алтан сарнайн мандал шиг туяараад
Тэнд зорьж очсон миний сэтгэлд
Тэр чигээрээ л яруу найраг байх шиг санагдлаа.

6. ГЭР РҮҮГЭЭ

- За найз аа, ажил явдал дуусаа биз дээ
Замаараа буцаад, одоо ч харин дарчихна биз дээ
Жолооч маант " гэр рүүгээ " гээд дуудаж байна гэсээр
Цовоолог нөхөр минь жин тан гэчихээд ороод ирлээ.

Өглөөний наран гялалзсан уул уурхайн хотыг
Өнгөт металл ялгагч том том үйлдвэрийг
Алаг хоёр нүдэндээ шингээн тусгаад явъя
Ажилчин анд нөхөддөө дуугаа үлдээгээд явъя

Үйлдвэрийн дотор зогсоод би металл ялгаагүй ч гэсэн
Үзгээ бариад гарвал яруу найрагч - ажилчин юм шүү
Урт мөртэй шүлгүүд минь дутуу дулимаг байлаа ч гэсэн
Үнэн мөний нь ажвал сэтгэлийн минь дуу юм шүү.

1955 он.

## УУЛЫН ҮЙЛДВЭРТ БОЛСОН ЦУГЛААН

Тэнгэрт ганц ч үүлгүй сайхан өглөө
Талбарт зөөлөн салхи сэвэлзсэн өдөр
Уурхайн ажилчид туг далбаа өргөсөөр
Уулын үйлдвэр рүү цуглаанд ирцгээлээ.

Аяны хүн миний сэтгэлд энэ цуглаан
Аятайхан санагдаж зүрх догдолсноор барахгүй
Зуны ажиллагаагаа энэ үйлдвэрийг нээхэд
Жил бүр оролцдог уурхайчид ч баяртай байлаа.

Манай үеийн ажилчин хүмүүс ирээд
Цуглаан хурал аль хэдийн нээгдээд
Сонгож авсан мэргэжлээ дээшлүүлэх тухайгаа

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Социалист уралдааны үүргээ давуулах тухайгаа

Хурлын индэр дээр ээлжлэн гарч
Хойно хойноосоо даган тасралтгүй очиж
Хангинатал гэгч сайхан ярьцгааж байлаа.
Халуун талархлаар үргэлж угтацгааж байлаа.

Хойд талаас машины дуу алгуурхан гарлаа
Хүмүүсийн хараа агшин зуур түүнд шилжлээ.
Хойно хойноосоо цувран яваа машинуудыг харахад
Хойд зүгээс ирдэг галт тэрэг шиг санагдлаа.

Үнэт баялаг ачсан цуваны түрүүчийн машин
Үйлдвэрийн эхний дамжлагад тулж ирээд
Улаан тууз таслан орж ачаагаа асгахад
Улын үйлдвэрүүд нижигнэж эхэллээ.

Мөнөөхөн хурлын ажиллаагаа үүгээр дуусч
Улын үйлдвэрийн зуны ажил нээгдэхэд
Уурхайчдын зүрхэнд шинэ зориг нэмэгдэн
Уралдаант их хөдөлмөртөө шаламгайлан орцгоолоо

1956 он.
Цэнхэрмандал

**АРГАГҮЙ Л МӨН . . .**

Шөнө арван цагт уурхайчдын хурал тарлаа.
Цэнхэрмандалаар тайван намуун шөнө налайжээ.
Хархүү хурал тараагаад гэртээ хүрч ирлээ.
Хамаг юм нь тавьсан янзаар, нэг л эвгүй ...

Хархүү галаа ноцоож, пийшин дээр цай тавиад
Харанхуй шөнийг цонхоор ширтэн ганцаар зогсохдоо
ХАйртынхаа сэтгэлийн үгийг дуулсан сартай шөнийг саналаа.
Хоёулаа цэцэрлэгийн дотуур зугааож явснаа бодлоо.

Одоо тасалгаа дулаан, хархүүгийн сэтгэл тэнүүн
Радиогоор ажилчин Алимаагийн тухай ярьж байна.
Тэр, их хурлын депутатад нэр нь дэвшсэн хүн юм.
Тэргүүний эсгүүрчин, ударник цолтой бүсгүй юм.

Хархүү уншиж байсан сонингоо орхичихоод
Хүүхний намтрыг чих тавин чагнан сууна.

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Амраг хүүхэн нь мөн байж, Аюушийн Алимаа гэлээ
Аж үйлдвэрийн комбинатад ажилладаг юм гэж ярилаа.

“ Аргагүй мөн, Алимаа минь “ гэж баясан хөөрөн босоод
Орныхоо ар дахь зургийн нь өмнө очиж ширтэн зогслоо.
Хайрт нь цогтой нүдээрээ инээмсэглэн урдаас нь ширтлээ
Хархүү “ Баярлалаа чамд “ гэж дахин давтан шивнэлээ.

1954 он.
Цэнхэрмандал

**НЭГДЭЛ**

Хунгийн сүрэг унтаж байх шиг
Загийн шугуйд айлууд цайрах юм.
Манай нэгдэл гэцгээгээд л говийнхон
Магнай тэнэгэр баяртай явах юм.
Олон хүүхдийнхээ хамгийн багад
Эх хүн хайртайн адил
Олуулаа эвлэсэн шинэ нэгдэлдээ
Энэ малчид чинь дуртай юм.

**ХӨДӨЛМӨР**

Алтан соёмбоор мялаалгасан сүүн цагаан хөдөлмөр
Авхаалж цогтой бидэндээ алдар гавъяа шагнаж
Ахин ихийг бүтээх алагхан зүохний хүслэнгээр
Аугаа эх орон минь алхаа товчлон урагшилж байна.

Өрхөөр гарсан оч шиг гялалзан бадрах зүтгэл маань
Өндөр тэнгэрийн хүйсэн дэх нар сар шиг туяаран
Өвгөн буурал дэлхийн атираат нүүрийг засалцаж
Өтгөн ногоон цэцэрлэгээр өвч биеийг нь хучиж байна.

Уулыг нүүлгэх чадалтай манай үеийн хүмүүсийн
Усыг эргүүлэх эрчтэй эх оронч хөдөлмөр
Угаас даруу зантай миний ард түмнийг
Униар татсан дэлхийн атираа бүхэнд алдаршуулж байна.

**СОНИН**

**“ Залуучуудын Үнэн “ сонинд зориулав.**

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Дэлгээд тавихад сонины хуудас
Дэлмийн хэмжээнд хүрэхгүй ч гэлээ
Ухаант хүнийг хүсэл мөрөөдөлтэй нь
Уужуу багтаасан талбар билээ.

Эвхээд авахад сонины хуудас
Энгэрийн халаасанд багтдаг ч гэлээ
Хан тэнгэрийг од сартай нь
Хамт багтаасан талбар билээ.

Жигнээд үзэхэд сонины хуудас
Жингийн туухай хөдөлгөхгүй ч гэлээ
Дэлхийн бөмбөрцөгийг хүн ардтай нь
Дээрээ багтаасан талбар билээ.

Худалдаад авахад сонины хуудас
Торгоны ар шиг нимгэн ч гэлээ
Нийт хүний хэл ярианы
Нэвтэрхий их толь билээ.

Дэлгээд тавихад сонины хуудас
Дэлмийн рэмжээнд хүрэхгүй ч гэлээ
Ухаант хүнийг хүсэл мөрөөдөлтэй нь
Уужуу багтаасан талбар билээ.

1964 он.

## ТЭШҮҮРЧДИЙН ДУУ

Торойх үүлгүй тэнгэр шиг
Толин цэнхэр мөсөн дээр
Тойрон наадсан мөрөөрөө
Үүлэн хээгээ тавьдаг
Тамирчин бид
Тэшүүрчин бид
Хулан шиг
Хурдалж чадна
Хун шиг
Дэвж чадна.

Хараацайн даль шиг хурцалсан
Хатан болд тэшүүрээрээ
Галуун цуваа шиг уралдаж
Гайхам чадлаа сорьдог

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Тамирчин бид
Тэшүүрчин бид
Сэлэнгэ шиг
Долгиолж чадна
Сэнс шиг
Эргэж чадна.

Ээжий аавынхаа заясан
Идэр биеэр жавхаалаг
Эх орныхоо ивээсэн
Итгэл халамжаар ухаалаг
Тамирчин бид
Тэшүүрчин бид
Яргуй шиг
Найгаж чадна
Янзага шиг дүүлж чадна.

Торойх үүлгүй тэнгэр шиг
Толин цэнхэр мөсөн дээр
Тойрон наадсан мөрөөрөө
Үүлэн хээгээ тавьдаг.
Тамирчин бид
Тэшүүрчин бид
Хулан шиг
Хурдалж чадна
Хун шиг
Дэвж чадна.

1965 он.

## УДМААРАА БИД АЖИЛЧИН

Хот айлын гадаа шинэ гэр барьсан шиг
Хот газрын хаянд шинэ үйлдвэр боссон юм.
Анхны тэр үйлдвэрт ууган ажилчилд элсүүлэхэд
Ам бүл нэмж өвөө минь орсон юм.
Удмаараа бид ажилчин
Үүгээрээ бид бахархана.
Анхны тэр үйлдвэр модон байшингаа орхиод
Аварга том чулуун барилгад орсон юм.
Ажилчны эгнээ жил бүр өргөжөөд
Аав минь тэр үйлдвэрт ажилчин болсон юм.
Удмаараа бид ажилчин
Үүгээрээ бид бахархана

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Эхр чөлөөт орноо ингэж хөгжүүлье гэж
Энхрий хайрт нам засаг зам заасан юм.
Уурхай, үйлдвэр энд тэндгүй сүндэрлээд
Удмаа дагаад би ажилчин болсон юм.
Удмаараа бид ажилчин
Үгээрээ бид бахархана
Төрөлх эх орны минь ирээдүй тод байна.
Түм буман ажилчны гар бяртай байна
Үр хүүхэд маань өсөж торнисоор байна.
Удмаа дагаад тэд бас ажилчин болцгооно.
Удмаараа бид ажилчин
Үгээрээ бид бахархана.

1971 он.

## ГОВИЙНХОН

Говийнхон гэдэг хэзээ ч говийнхон
Говьдоо зохицож идээшсэн ажлынхан
Говийнхонд хөлс гэдэг үнэгүй
Говийнхонд ус гэдэг үнэтэй.

Тээрч шургасан горхины үзүүрийг
Тэвнэнд сүвлэсэн утас шиг өргөж
Хөндлөн даланд татаж аваачаад
Хөөрхөн гэгчийн нуур тогтооно.

Хөлд нь тэгээд тариа тарина,
Хүнсний ногоо дэргэд нь тарина.
Одоохондоо од шиг жижигхэн ч гэлээ
Оддоос гэрэлтэй алим тарина.

Жимс ногооны тариалангийн дэргэд
Жижигхэн далангийн хиймэл нуур
Зээрийн хоолойн зэрэглээн дунд
Жигтэйхэн том тэнгис шиг харагдана.

Говийнхон гэдэг хэзээ ч говийнхон
Говьдоо зохицож идээшсэн ажлынхан
Говийнхонд хөлс гэдэг үнэгүй
Говийнхонд ус гэдэг үнэтэй.

Таанат говь уудам ч гэлээ
Тархаад бэлчвэл багтахгүй гэмээр

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Таван хлшуу малтай хэрнээ
Тэмээндээ говийнхон илүү хайртай.

Сайрын эхний өрөмдмөл худаг дээр
Сайхан тэмээдээ услахаар ирэхдээ
Амны цангаагаа эхэлж гаргалгүй
Атан тэмээдээ л яаран усална.

Од шиг олон тэмээдээ усалсаар
Оройтож байж гэртээ ирээд
Тэмээний сүүтэй цайгаа ууна.
Тэгэхэд л нэг цангаа нь гарна.

Говийнхон гэдэг хэзээ ч говийнхон
Говьдоо зохицож идээшсэн ажлынхан
Говийнхонд хөлс гэдэг үнэгүй
Говийнхонд ус гэдэг үнэтэй.

Гэрийнх нь барааг өглөө хараад
Гэмгүй бас яарсхийж яваад
Оройтож ирсэн зочноо угтаж
Олбог дэвсэн хоймроо урина.

Худагтай усаа дундлах шахан
Хувинтай сүүгээ юүлэх алдан
Тогоо дүүрэн цайгаа чанаж
Тостой ааруулаа таваглаж дайлна.

Аагтай цайг нь амталж суугаад
Алтан говийнг нь магтаж ярьвал
Хүн малын нь амьдрал болсон
Худагтай усаа ч бэлэглэх дөхнө.

Говийнхон гэдэг хэзээ ч говийнхон
Говьдоо зохицож идээшсэн ажлынхан
Говийнхонд хөлс гэдэг үнэгүй
Говийнхонд ус гэдэг үнэтэй.

Шургасан горхиноос нуур тогтоож
Шуурсан элснээс алим ургуулж
Нутгийн тэмээнээс үүлдэр тодруулж
Нуугьсан сүүнээс нь цөцгий ялгаж

Тэнгисийн эрэг сахисан улсаас
Дутахгүй амьдарч байгаа хэрнээ
Хэнтэй ч уулзсан усны тухай л

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Хэрэг болгож говийнхон ярина.

- Зэрэглээ гэдэг ус биш дээ
Зэрэглээний дайтай устайсан бол
Номин говь минь өдийд ийм байхгүй гэж
Амин голын яриа дэлгэнэ.

Говийнхонд ус гэдэг үнэтэй
Говийнхонд хөлс харин үнэгүй
Говьдоо зохицож идээшсэн ажлынхан
Говийнхон хэзээ ч говийнхон.

1979 он.
Өмнөговь

## ДАЛАНЗАДГАДЫН ТАРВАС

Даланзадгадын тарвас
Даамай сайхан амттай
Зоогийн ширээнд тавихад
Зургаан килийн жинтэй.

Өнгөн хальс нь ногоохон
Өехий дотроо ягаахан,
Голдоо бүүр улаахан
Гойд сайхан тарвас байна.

Глвийн борхон бүсгүй
Зүсэн зүсэн таваглах юм.
Холын гийчин намайг
Зэрвэс зэрвэсхэн ажих юм.

Наранд ойрхон ургаад
Нарны цацраг будаа юу?
Сайхан говийн бүсгүйн
Сэтгэлийн амт шингээ юү?

Тавган дээр ягаарах нь
Хазаад авмаар сайхан байна.
Таваглаж яваа бүсгүй
Үнсээд авмаар хөөрхөн байна.
Жимсний амтыг авсан хойно
Жингээр идэхээс ч буцахгүй
Зэрвэсхэн ажихыг нь мэдсэн хойно

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Жилээр удсан ч мартахгүй.

Даланзадгадын тарвас
Долоон кило болж томорно.
Даланзадгад хотод би
Дахиад заавал ирнэ.

1979 он.
Даланзадгад хот

## ЭЭЖДЭЭ

Энхрийлж өсгөсөн ээжий минь
Эрхэм сайн суугаарай
Эрхлүүлж өсгөсөн хүү чинь
Эрдмийг сураад ирье.
Аглаг талын малчин ээжий минь
Амар сайн суугаарай.
Алсад байгаа хүү чинь
Ачит эрдмийг сурч байна.
Шижир туяат танхимдаа
Шамдаж эрдмийг сурахдаа
Ачит буурал ээжийдээ
Амжилтаа үргэлж дуулгана.
Эрдмээрээ гийгүүлсэн энэ сургуулиа
Эрхэм сурлагаар төгсгөнө
Эх орондоо байгуулах гавъяагаар
Ээжийнхээ ачийг хариулна.

1949 он.

## АЛАГ ҮР МИНЬ ТАЙВАН НОЙРС

Бимаа охин тасалгаандаа нойрсоно.
Бяцхан бамбарууш өвөрт нь нойрсоно.
Бимаагийн зүрх түг түг цохилно.
Байшингийн цаг чиг чиг дуугарна.

Ээж нь сэмээрхэн дэргэд нь очоод
Эвтэйхэн гэгч хөнжлийг нь заслаа
Алаг үр минь тайван нойрс гэж
Аман дотроо шивэгнэж хэллээ.

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Оройн ээлжинд явсан эцэг нь
Онцгой баяртай гаднаас ирлээ.
Бимаагийн ээж гараа хөдөлгөн
“ Чимээгүй “ гэж дохио өглөө.

Охиноо унтсаныг аав нь мэдээд
Огтхон ч чимээгүй дэргэд нь очлоо.
- Станокийн дэргэдээс аав чинь ирлээ.
Охин чамайгаа санасаар ирлээ.

Өдөржин тоглоод чи минь ядраа юу?
Алаг үр минь тайван нойрс гэж
Эхийнх нь хэлдэг нандин үгийг
Эцэг нь давтаж аяархан хэллээ.

Бимаа охин тасалгаандаа нойрсоно.
Бяцхан бамбарууш өвөрт нь нойрсоно.
Бимаагийн зүрх түг түг цохилно.
Байшингийн цаг чиг чиг дуугарна.

1953 он.

## ЭЖИЙ МИНЬ БИ МАРГААШ ЯВЛАА

Маргааш явлаа
Эжий минь би
Маргааш явлаа.
Манхан тэнгэрийн
Хаяа руу
Манарсан талын
Тэртээ рүү ...
Хүнд хөлөө
Таны хүргээгүй
Холын холд
Хүү чинь явлаа.

Аавын бий дээр
Хүнтэй танилц гэж
Агтын бий дээр
Газар үз гэж
Хал сайтай
Өмөг эх минь
Цал буурал

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Үсээ илэнхэн
Төрсөн ганц
Хүү наддаа
Дуулсан сургаалаа
Хэлдэгсэн та.

Одоо хүү чинь
Маргааш явлаа.
Ор мэдэхгүй
Хүний нутаг руу...
Ойн дунд
Өнчин ургасан
Орь ганц
Агар мод шиг
Өөр зүстний
Дунд амьдрана.
Өлзийт эхээ
Үргэлж дурсана.

Үдшийн бүрийд
Ихэр ишгийг
Буман хонинд
Салгаж тавихад
Үүрийн харанхуйд
Өөрсдийгөө олоод
Бувар бувар
Хивдэг байхад
Авхаалжит хүний
Үр би чинь
Анд нөхдөө
Олж ханилна.

Маргааш явлаа
Эжий минь би
Маргааш явлаа.
Усны гүнийг
Загас эрдэг шиг
Нутгийн сайхныг
Би эрээгүй.
Гэрлийн зүг
Эхвээхэй нисдэг шиг
Эрдмийн зүг
Зүрх минь тэмүүлж
Багаас ихэд
Хүрдэг бодогдоно.
Намаас өндөрт

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Ахидаг санагдана.

Маргааш явлаа
Эжий минь би
Маргааш явлаа.
Эрхий мэргэний
Тавьсан сум
Бай онодог
Гэлүү дээ, та
Эр хүний
Гэгээрсэн ухаан
Нэгийг бүтээдэг
Гэлүү дээ та
Маргааш явлаа
Эжий минь би
Маргааш явлаа.
Намар буцсан
Алаг ангир
Хавар эргээд
Ганганан ирдэг шиг
Нэг л мэдэхэд
Хүү чинь ирнэ.
Яг л дүрээрээ
Хүрээд ирнэ.

Эрийн цээнд
Хэдийн хүрээд
Элдвийг эргэцүүлж
Боддог болсон
Хүний үр
Би байтугай
Хайрт нутгийнхаа
Торгон элсэнд
Хумсын чинээхэн
Туурайгаа тавилгүй
Эхийнхээ гэдсэнд
Харьд худалдагдсан
Унага нутагтаа
Гүйдэг гэнэ лээ.

Маргааш явлаа
Эжий минь би
Маргааш явлаа.
Угиар татсан
Цэнхэр талдаа,
Ууртаа шитүүлсэн

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Хайрт эжийдээ
Энхрий хүү чинь
Эргэж ирнэ.
Эрдэм сураад
Буцаж ирнэ.

1954 он.

## ЭХИЙН ТУХАЙ ДУУ

Анх удаа алхаж байгаа хүүгээ эх нь
Ар өврөөс нь дэмжихийг үзээд
Ай хө
Ээжийгээ би зүйрлэнхэн санадаг даа.

Цонхон дороос хоол олоод борхон болжмор
Цохолж ангаахайдаа нисэхийг хараад
Ай хө
Ээжийгээ би зүйрлэнхэн санадаг даа.

Цөөрмийн усанд дэгдээхэйгээ сэлж сураг гэж
Цөхөртлөө харуулдагч ангирыг үзээд
Ай хө
Ээжийгээ би зүйрлэнхэн санадаг даа.
Өөрөөсөө өчнөөн өндөр хүүгээ үнсэх гэж
Өвөр өөд нь зүтгэгч эхийг хараад
Ай хө
Ээжийгээ би зүйрлэнхэн санадаг даа.

1955 он.

## ЭНХАМГАЛАН ЭЭЖИЙ

Мод модны дундаас эгцхэн ургадаг
Мөнх ногоон агар
Мянга түмний дундаас сайхан харагддаг
Миний хайрт ээжий.

Эргэх дөрвөн улиралд өнгөө сольдоггүй
Эгцхэн ногоон агар
Энэ яваа насанд хайраа хувиргадаггүй
Энх амгалан ээжий.

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

1957 он.

## ЭХ
**Охин дүү Бямбаадаа**

Эх болсон чи унтах нойр, уух цайгаа мартаж
Эрхийн чинээ үрдээ л дуу дуулж сууна.
Инээмсэглэн зүүдлэгч үрийн чинь бяцхан нүүр
Эгээ л чамд арван тавны сар шиг харагдана.

Гайгүй ээ, нэг д мэдэхэд үрийн чинь хөл дөрөөнд хүрч
Гал шиг халуун хайрыг чинь мэдэх цаг ирнэ.
Онгон буурал үсний чинь доорх үрчгэр царайг
Орчлонгийн нартай зүйглэж хүү чинь чамайг хайрлана.

1956 он.

## ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ТУХАЙ ДУУ

Төрөлх сайхан орондоо
Төө зайгүй хайртай
Түмний манлай намдаа
Төрсөн үрийн сэтгэлтэй
Хангайн цэцгээс сайхан
Хангал согооноос жавхаатай
Эмэгтэйчүүдийн алдрыг
Эгшигт дуундаа магтая.
Уралдан хийх хөдөлмөрт
Үүлэн борын хурдтай
Урлан бүтээх ажилд
Уран гарын эрдэмтэй
Хангайн цэцгээс сайхан
Хангал согооноос жавхаатай
Эмэгтэйчүүдийн алдрыг

Эгшигт дуундаа магтая.
Хүн ардын дотроос
Хүний эхийн алдартай
Хүнийг хайрлах сэтгэл нь
Хүжийн галын илчтэй
Хангайн цэцгээс сайхан

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Хангал согооноос жавхаатай
Эмэгтэйчүүдийн алдрыг
Эгшигт дуундаа магтая.
Цэнхэр номин огторгуй
Одод үгүй бол үзэмжгүй
Энхэр ард түмэн минь
Эхчүүдгүй бол өнөргүй
Хангайн цэцгээс сайхан
Хангал согооноос жавхаатай
Эмэгтэйчүүдийн алдрыг
Эгшигт дуундаа магтая.

1960 он.

## ЭЦГИЙН ДУРСГАЛД

Хангайн өндөр уул шиг
Нөмөр түшигтэй явсан
Хан буурал эцэг –
Миний хайрт аав аа.

Өргөн их дэлхий шиг
Өлзий буянаа хайрласан
Өвгөн буурал эцэг –
Бидний хайрт аав аа.
Эхээс намайг гармагц
Хайрласан хүн та билээ.
Эмээлийн минь олмыг анх
Чангалсан хүн та билээ.

Алд биеийг минь бойжуулж
Өсгөсөн хүн та билээ
А үсгийн дуудлагад
Сургасан хүн та билээ.

Хайнагын шарны эвэр
Хөлдөж унамаар хүйтэнд ч
Халуун өврийн чинь илчинд байж
Даараагүй билээ, би чинь

Халтар нохойны гаслам
Ган халуун наранд ч
Ханхар цээжний чинь сүүдэрт сууж
Халаагүй билээ, би чинь.

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Идэр залуу насандаа
Эцэг танаасаа хагацлаа.
Эцэг үрийн хагацлыг
Энэ биеэрээ эдэллээ.

Хорвоогийн жамыг дагаж
Хонгор сэтгэлээ чангалъя
Авъяас чадлын хэрээр
Ачийг чинь хариулахыг хичээе.

Үр хүүхэд биднийгээ
Элбэг дэлбэг өсгөх гэж
Өлөн бугын гүйдэг
Үүрээр анд морддогий чинь

Сартай хүрэн мориндоо
Дааж ядтал нь ганзагалаад
Сайхан хангайн хишгийг
Бидэндээ авчирч өгдөгий чинь

Үр хүүхдээ тэжээх гэж
Ан Амьтан хороогоод
“ Үлгэрийн далай “ уншиж
Нүглээ наманчилж суусныг чинь ,

Үр хүүхдээ өөрөөсөө
Өндөр болчихоод байхад нь
Өчүүхэн нялх хэвээрээ гэж
Өхөөрдөж суусан хайрыг чинь
Гангар хүйтэн өвөл
Хөлий минь даарuулалгүй өсгөсний чинь
Ган халуун зун
Амы минь цангаалгү бойжуулсны чинь

Санан санан явж
Сайн үйлсийг бүтээе.
Тэнгэрлэг сайхан зангий чинь
Тэр чигээр нь дуурайя.

Овоо доо, тэдний хүү гэж
Олон түмэндээ хэлүүлье
Аавынхаа сайныг дуурайж гэж
Ах дүү нартаа таалуулья

Эцгийн шарилыг хадгалсан

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Эх орноо хүндэлж явъя
Эгшиг налархай шүлгээрээ
Насан турш дуулъя.

Цэцэн цэлмэг цээжнээсээ
Авъяасаа хайрласан эцэг минь
Цэнхэр номин тэнгэр шиг
Ариун дүрт аав минь

Сайхан таныхаа хайрласан
Саруул тунгалаг оюундаа
Сар шиг гоолиг дүрийг чинь
Үүрд мөнхлөн хадгалъя

Униарт тал нутгаа
Хөшөөг чинь гэж харж явъя
Ухаа хонгор шороогий нь
Биеий чинь гэж хайрлаж явъя.

Хангайн өндөр уул шиг
Нөмөр түшигтэй явсан
Хан буурал эцэг –
Миний хайрт аав аа.

Өргөн их дэлхий шиг
Өлзий буянаа хайрласан
Өвгөн буурал эцэг
Бидний хайрт аав аа.

1961 он.

## РЕКВИЕМ

Хайртай ээжийнхээ шарилыг эргэн нэг очив.
Хархан хоёр нүднээсээ нулимс нэг дусаав.
Хайртай ээжийнхээ шарилыг эргэн нэг очиход
Ханагар нутгийн минь шороо ханхийн үнэртэв.
Ханагар нутгийнхаа шороонд шингээ юм байлгүй.

Цэвэрхэн ээжийнхээ шарилыг эргэн нэг очив.
Цэцгий хоёр нүднээсээ нулимс нэг дусаав.
Цэвэрхэн ээжийнхээ шарилыг эргэн нэг очиход
Цэцгийн сайхан үнэр сэнхийн үнэртэв.
Цэлгэр нутгийнхаа цэцгэнд шингээ юм байлгүй.

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Сайхан эжийнхээ шарилыг эргэн нэг очив,
Сормост хоёр нүднээсээ нулимс нэг дусаав.
Сайхан эжийнхээ шарилыг эргэн нэг очиход
Саруул нутгийн минь салхи сэвхийн илбэв.
Саоуул нутгийнхаа салхинд шингээ юм байлгүй.

Ачтай эжийнхээ шарилыг эргэн нэг очив,
Алаг хоёр нүднээсээ нулимс нэг дусаав.
Ачтай эжийнхээ шарилыг эргэн нэг очиход
Ахуй нутгийн минь агаар сэнхийн үнэртэв,
Ахуй нутгийнхаа агаарт шингээ юм байлгүй.

Ээлтэй ээжийнхээ шарилыг эргэн нэг очив.
Эрэвгэр хоёр нүднээсээ нулимс нэг дусаав
Ээлтэй ээжийнхээ шарилыг эргэн нэг очиход
Эх нутгийн минь наран налсхийн ээв,
Ээх нарныхаа цацрагт шингээ юм байлгүй.

Ухаантай ээжийнхээ шарилыг эргэн нэг очив.
Урсгал хоёр нүднээсээ нулимс нэг дусаав.
Ухаантай эжийнхээ шарилыг эргэн нэг очиход
Уугуул нутаг минь бүхлээрээ цэлсхийн үзэгдэв.
Уугуул нутгаа хайрладгийн учир энэ байлгүй.

1964 он.

## АМАР

Амар гэдэг нэртэй хөөрхөн хүүтэй болоод
Аргалчин ээжийнхээ ачийг эргэж нэг дурсав.
Аргалчин ээжийнхээ ачийг эргэж нэг дурсахдаа
Тэртээ уулын бэлээс үүрэн ирдэг байсан
Тэмээн тэнгийн арагт нь дарагдах шиг болов.

Амар гэдэг нэртэй хөөрхөн хүүтэй болоод
Анчин аавынхаа ачийг эргэж нэг дурсав.
Анчин аавынхаа ачийг эргэж нэг дурсахдаа
Хүйтэн асганы ёроолд дэвсэн хэвтдэг байсан
Хөлстэй нимгэн тохомд нь хайрагдах шиг болов.

1964 он.

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

## ӨЛГИЙН ДУУ

Үүлэн дундаа мэлмэрсэн
Үдшийн саран нойрсоорой
Өлгий дундаа тормойсон
Бяцхан үр минь нойрсоорой.
Бүүвэй
Бүүвэй
Бүүвэй
Бүүвэй

Нууран дундаа нуугьсан
Нугасны дэгдээхэй нойрсоорой.
Нойрон дундаа талимаарсан
Бяцхан үр минь нойрсоорой.

Бүүвэй
Бүүвэй
Бүүвэй
Бүүвэй
Бүрийн дундаа бүүдийсэн
Бүрэнхий үдэш нойрсоорой.
Бүүвэйн дуундаа уярсан
Бүлтгэр хүү минь нойрсоорой.

Бүүвэй
Бүүвэй
Бүүвэй
Бүүвэй
Ачит эхдээ мишээсэн
Айлын маамуу нойрсоорой.
Аав д ээждээ заясан
Алаг үр минь нойрсоорой.

Бүүвэй
Бүүвэй
Бүүвэй
Бүүвэй

1965 он.

## МИНИЙ ХУУЧИН ГАДУУР ЦАМЦ

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Халаасны нь ёроол цоорхой
Хуучин гадуур цамцтай юм би
Хал сайтай ээжийгээ л
Оёчих вий гэж айх юм би.

Өлчир бага насандаа ч
Өөдтэй явж чадаагүй ээ би
Үзэгдэж харагдсанаа өшигчөөд л
Эсгий оймсоо цоолдогсон,
Эжий минь л цойлдож суудаг сан.

Эрийн цээнд хүрлээ гээд
Ээжийнхээ гарыг амраагаагүй
Айлын залуустай барилдаад
Дээлийн сугыг урдагсан,
Ээж минь л оёж өгдөг сөн.

## ТЭР ЗҮГИЙН ТЭНГЭР САЙХАН

Цэлгэрхэн талыг яасхийгээд туулъя даа.
Чинийхээ үгийг яасхийгээд сонсьё доо
Чиглэсэн сэтгэл минь хэвээрээ байхад
Цэрвүүн холыг туулаад хүрнээ.

Чиний минь суугаа тэрхэн зүгийн
Тэнгэр нь хүртэл сайхан байдаг нь
Хүний үр чамд дурласны минь
Хамгийн наад талын тэмдэг нь болов уу?

Алагхан зүрхээ яасхийгээд амраая даа
Амрагхан хонгортоо яасхийгээд очьё доо
Аргамаг борыгоо бариад унавал
Амрагийн минь гэрт хүргээд өгнөө.

Чиний минь суугаа тэрхэн зүгийн
Тэнгэр нь хүртэл сайхан байдаг нь
Хүний үр чамд дурласны минь
Хамгийн наад талын тэмдэг юм болов уу?

Холчхон борыгоо уургалаад барья би
Холын амрагтаа зориод очьё би
Хонгорхон сэтгэл нь хэвээрээ байвал
Хойшдынхоо амьдралыг холбоод ханилъя

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Чиний минь суугаа тэрхэн зүгийн
Тэнгэр нь хүртэл сайхан байдаг нь
Хүний үр чамд дурласны минь
Хамгийн наад талын тэмдэг нь болов уу?

1953 он.

## ЭХЧҮҮДЭД ЗОРИУЛСАН БҮҮВЭЙ

Үүлгүй тэнгэрт одод ер унтдаггүй
Үй түмэн эхчүүд шөнө бараг унтдаггүй
Алаг үрсийнхээ төлөө тэд ингэж
Атгахан нойроо хугасалж суудаг юм.
Сарны мөнгөн туяан дор
Сайхан эхчүүд нойрсоцгоо
Бүүвэй
Бүүвэй
Хээрийн хайгуулд яваа охины араас,
Хилийн цэрэгт байгаа хүүгийнхээ хойноос
Чинхүү сэтгэлээ эхчүүд бэлчээж
Чимххэн нойроо хугасалж суудаг юм.

Сарны мөнгөн туяан дор
Сайхан эхчүүд нойрсоцгоо
Бүүвэй
Бүүвэй
Саваагүй зарим нь болзоонд яваад оройтоход
Санамсаргүй нэг нь хүйтэн үгэнд өртөхөд
Сав л хийвэл эхийн зүрх түгшиж
Сайхан нойроо хугасалж суудаг юм.
Сарны мөнгөн туяан дор
Сайхан эхчүүд нойрсоцгоо
Бүүвэй
Бүүвэй
Хүж дэлхий амгалан энх байгаасай гэж
Хүн ард элэг бүтэн жаргаасай гэж
Хорвоогийн эхчүүд хүний төлөө ингэж
Хомсхон нойроо хугасалж суудаг юм.

Сарны мөнгөн туяан дор
Сайхан эхчүүд нойрсоцгоо
Бүүвэй
Бүүвэй

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

1975 он.

Үлэмжийн сайхан хорвоод тээж төрүүлсэн эжийгээ
Үсэн буурал болох бүр үе үе л санах юм.
Үүрийн цагаан гэгээтэй урьтан золгох энгэрт
Үүрд нойрссон шарилыг нь байн байн эргэх юм.

Ингэн хавтгайн сүүгээр цай сүлж уулгасан биш
Ээжийнхээ ачийг би юугаар хариулсан гэх вэ дээ
Эмийн цэцэгсийн шүүдрээр дарс нэрж дайлсан биш
Эх үрсийн өрийг би юугаар төлсөн гэх юэ дээ

1977 он.

## ЗАХГҮЙ ХӨХ ТЭНГЭРИЙН ДОР

Нар саран чимэгтэй байхдаа
Нарлаг дэлхий гэрэлтэй сайхан
Навч цэцгэн хучлагатай байхдаа
Эх орон минь гоёмсог сайхан.

Захгүй хөх тэнгэрийн доор
Залуу ногоон цэцэрлэгийн дунд
Зан хөөрхөнтэй чинийхээ хамт
Зугаалж явах баяртай сайхан.

Түгээмэл байгалийн жигдрэл дундаас
Туулын урсгал тунгалаг сайхан.
Түмэн олон залуусын дундаас
Дурласан амраг чи минь сайхан.

Эрх чөлөө бялхам дүүрэн
Эх орны иргэн бид хоёр,
Ихэр юм шиг ижилдэн дассан
Идэр залуу нас минь сайхан

Үүрийн туяа дорноос цайхад
Үүрэгт ажилдаа бид шамдана.
Үдшийн бүрийгээр буцаад харихад
Учралт чи минь угтан мишээнэ.

Цэлмэг залуу насны минь зүрх
Чинийхээ дэргэд амар тайван.

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Эрвээхэй хоёр нүдээрээ инээмсэглэж
Эгцэлж намайг ширтэх чинь сайхан.

Нар саран чимэгтэй байхдаа
Нарлаг дэлхий гэрэлтэй сайхан
Навч цэцгэн хучлагатай байхдаа
Эх орон минь гоёмсог сайхан.

Захгүй хөх тэнгэрийн доор
Залуу ногоон цэцэрлэгийн дунд
Зан хөөрхөнтэй чинийхээ хамт
Зугаалж явах баяртай сайхан.

1953 он.

## Дээвэр дэвэх салхи

Цалгилсан мөрний давалгаа шиг
Халгилсан хайрын нандин дуугаар
Хайрлан дурласан янаг чамдаа
Хамгийн түрүүнд зориулъя би

Сонинхон зэрэглээ сүүмэлзэн наадсан
Саруулхан нутгийнхаа хөхрөгч хөндийд
Арвихан сүргээ хариулж явахдаа
Анх чамайг харсан минь золтой.

Дээвэр дэвэх салхи нь илбэсэн
Дэлгэрхэн талыг чимсэн айлын дунд
Дуртайхан амраг чамтайгаа би
Дун цагаан гэрээ барихыг хүснэм.

1954 он.

## АЙ ДАА ДУУЛ, АЛТАН ГУРГАЛДАЙ МИНЬ

Ай даа дуул, алтан гургалдай минь
Алга ташилт нижигнээд байна шүү.
Аагтай сайхан хоолойнд чинь уяраад
Ахиад чамайг уриад байна шүү.

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Дууллаа, дуугий чинь алтан гургалдай минь
Дуниаран хөхрөгч алсын алсад
Дуран хар нүдтэй бүсгүй минь байдаг юм,
Дуугий чинь сонсоод би уулзсан шиг баяслаа.

Ахиад нэг дуул, алтан гургалдай минь
Алсад суугаа тэр минь сонсдог.
Аяс налархай хоолойнд чинь уяраад
Амраг надтайгаа уулзсан юм шиг баясаг.

Дуул даа дуул, алтан гургалдай минь
Дуниарах алсад дуулдтал дуул
Чиний хоолой тэртэй тэргүй
Чээжин дэх нууцыг минь хэлүүлчихсэн юм чинь

1953 он.

Хөдөө нутагт малчдын өвөлжөө зайдуу
Хүүрэгт хөндийн явуулах зай арвин
Хүүхэн хонгорын болзсон болзоо хатуу
Хүйтэн шөнө морин туурай хөнгөн

1955 он.

Хоорондоо тэр хоёр ухаан алдам дурлаад
Хуримаа хийж айл гэр болон ханидан суужээ.
Харин анх яагаад дурлалцсанаа хоёул мэдсэнгүй
Хожим инээлдэж бие биеэсээ асуудаг байжээ.

Хорвоогийн насыг тэр хоёр хамт барахдаа
Хөндлөнгөөс атаархам үртэй, эвтэй өнөр явжээ.
Хоёр биедээ чухам яагаад тэгж дурласнаа
Хэн нь ч гэсэн бүх амьдралдаа олж мэдсэнгүй.

1955 он.

Эрвээхэй хоёр нүд чинь
Ирмэхээ мартаад ширтэх юм.
Эгцлээд харахын зуурт минь
Дальдраад харцаа буурuулчих юм.

Цохлоод ширтэх нүд чинь
Цэцэг дээр суугаа эрвээхэй шиг ээ
Ичээд доошоо харах чинь

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Эрээн эрвээхэй нисэх шиг ээ

Эрээн алаг эрвээхэй нь
Хичнээн цэцэг дээр суугаа бол ?
Эрвэгэр хархан нүд чинь
Хичнээн хүн дээр тусаа бол ?

Эргэлдэн нисэх эрвээхэй нь
Амтат балыг олдог шиг
Ирмэхгүй ширтэх нүд чинь
Арай намайг олсон юм биш биз ?

1955 он.

## МОНГОЛ НУТГИЙН ШӨНӨ

Шөнийн дуу

Мөнх хөх тэнгэрт
Мөнгөн сар инээмсэглэж
Амгалан шөнийн дэлхийд
Алиман туяагаа тусгана.

Гүн ногоон ой нь
Шуугин шуугин найгана.
Гүнзгий тунгалаг голын минь
Дөлгөөн долгио мяралзана.

Очин гэрэлт од мичид
Орой дээр минь гялалзана.
Онгон зүрхний янаг минь
Миний дэргэд туяарна.

Цайдам талд нь бойжсоноо
Санан санан суухад
Удам монгол нутгийн минь
Шөнө ч хүртэо сайхан аа

Мөнх хөх тэнгэрт
Мөнгөн сар инээмсэглэж
Амгалан шөнийн дэлхийд
Алиман туяагаа тусгана.
1955 он.

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

## БИ ЧАМД ХАЙРТАЙ

Холоос гүйдэлтэй борлог минь
Сульдаа ганхам жороо доо
Голоос хайртай амраг минь
Шөнөдөө гэрэлтэм царайлаг даа

Сэрүүн булгын усанд
Цэлмэг тэнгэр гэрэлтэх шиг
Ариун зүрхний гүнд
Цэвэрхэн дүр чинь тодроно.

Атар хээрийг чимэглэсэн
Алаг цэцгэнд би дуртай
Ариун хайрыг минь булаасан
Амраг чамдаа би хайртай.

Жороо борлогоороо тэшүүлсээр
Жолоо тавьсгээд очно доо
Жаалхан чи минь инээсээр
Баахан гэрэвшисгээд золгоно доо.

1955 он.

## ЕРТӨНЦИЙН ХҮҮХНҮҮД ЦЭВЭРХЭН ТӨРЖЭЭ

Залуу сайхан охидуудаас
Царайтай, царайгүйд нь хүрээд л
Зарим хүмүүс зааглаж дугаарлах санаатай байх юм.
Өөрийнхөө дурласан хүүхнийг цэвэрхэнд нь тоолоод л
Өрөөл бусдыг нь барагтай гэж хэлэх гээд байх юм.
Хэзээний би энэ дүгнэлттэй эвлэрч яваагүйгээс
Хэрэг болгож өөрийнхөө саналыг хэлэх гэж байна.
Ертөнцийн хүүхнүүд цөмөөрөө цэвэрхэн төрдөг юм.
Яагаад гэвэл цугаараа нөхөрт очирцгоодог байна.
1955 он.

Тэнгэрт мэлмэрэгч тэргэл сар
Даанч сайхан гэрэлтэй сар аа
Дэргэд минь суугаа амраг чи
Мөнч цэвэрхэн хүний үр ээ

Гэрэлт од чиний сайханд
Гялбасан юм шиг анивчаад байна.

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Гэгээн шөнө чиний тоог
Гайхсан юм шиг чимээгүй байна.

Эрвээхэй хоёр хөөрхөн нүд чинь
“ Үнсээч “ гэх шиг ширтээд байна.
Идэр насны борхон зүрх минь
“ Хэлээч “ гэх шиг булиглаад байна.

Аав ээжээс анх төрсөөр
Ариун байгаа дурлалаа ханзлая би
Хамаг насаараа хамт амьдрахаар
Халуун байгаа хайраа өгөөч, чи

Тэнгэрт мэлмэрэгч тэргэл сар
Даанч сайхан гэрэлтэй сар аа
Дэргэд минь суугаа амраг чи
Мөнч цэвэрхэн хүний үр ээ

1955 он

Удам монгол холхон
Довтлогч морин хүрэхгүй
Учирсан янаг алсхан
Долоон хоногийн тэртээ

Өргөн далайг гатлахад
Үрээ мориор яах юм бэ?
Өөрийн амрагийг байхад
Өөр хүнээр яах юм бэ?

Тусаад байгаа нарны зүгт
Өсөж төрсөн нутаг бий
Дурсаад байгаа зүрхний угт
Захиж хэлсэн үг нь бий.

Агсам морины туурайнд
Замын нуруу хотойхгүй
Амлаж хэлсэн үгнээсээ
Аавын хүү буцахгүй.

1955 он.

**ЧАМДАА ДУУЛЪЯ**

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Талын шаргал тарианы
Алтанхан долгио давалгаалахад
Танхил хонгор чамд
Дассан сэтгэл минь тэмүүлнэ.

Хүний үрд дасна гэдэг
Хэцүү юм даа, хонгор минь
Хангайн буга шиг амьдрахад
Хайрт чи минь дутах юм.

Халуун намрын салхинд
Дээлийн хормой хийсэхэд
Хагацал амссан зүрх минь
Дэндүү чамайгаа мөрөөдөх юм даа

Газрын энэхэн холоос
Ганьхарч дуулсан дуу минь
Өөрийг минь төлөөлж очоод
Үгийг минь үглэдэг ч болоосой

Талын шаргал тарианы
Алтанхан долгио давалгаалахад
Танхил хонгор чамд
Дассан сэтгэл минь тэмүүлнэ.

1958 он.

Гоо сайхан энэ бүсгүйн хацар дээр
Гунигийг нь илчилж, ганц дусал нулимс цэхийнэ.
Дав дээр харахад хумсны толионоос ч жижигхэн
Даан удалгүй нэг л арчилтаар алга болчихно.

Харин хэзээ хойно ганц дусал энэ нулимс
Хэн нэгний сэтгэлд тэнгис адил үзэгдэнэ.
Алган дээрээ орчлонг тавиад учирлан гуйсан ч
Арилгаж чадахгүйгээ мэдэж, тэр хүн гэмшинэ.

1956

Түмэн одод алсад гялалзсан шөнө
Төө зайгүй нөхөрлөл минь энд эхэлж билээ.

Хун шувуу хос хосоороо амьдардаг шиг
Хүний үрс хорвоогийн жамыг бас л дагах юм.

Үүрийн туяанд талын үзэсгэлэн тодорч

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Үгээ таслан гоо сайхныг нь сонирхоход

Залуу навчсыг салхи үлээн хөглөж
Залгаж хэлэх үгийг байгаль хүртэл хүлээж билээ.

Сонсож байна уу? хайртай би чамдаа гэдэг үгийг
Шивнэх навчис одоо хүртэл давтсаар байна шүү.

1956 он.

Гэгээвчин дор үүрээ барьдаг
Голын хараацайг хөөрхийлэлтэй
Учирсан дор үгээ хэлдэг
Гэнэн бүсгүйг өрөвдөлтэй.

1956 он.

**Тал нутгийн эзэн бүсгүй**

Гурвaар дарсан хархан гэзгээ
Газар шүргэм арагш нь хаяад
Алгаар эргэлдсэн хөөрхөн нүдээ
Хацар цоргим нааш нь ширтээд

Танаар бадарсан цагаахан шүдээ
Бахдал төртөл яралзуулан инээж
Галаар төөнөсөн халуухан гараа
Баясал сэргэтэл харамгүй атгуулж

Уулзах болгондоо хайрыг бэлэглэж
Учрах болгондоо жаргалыг авчрагч
Тал нутгийн эзэн бүсгүй чамд
Гал дөлийн хайраар би дурлана.

1956 он.

**АНИВЧИН ГЯЛАЛЗАХ ОДОД**

Мэлтэс мэлтэс гэрэлтээд
Саран гарах сайхан

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Мэлмэс мэлмэс туяараад
Чиний минь ирэх дулаахан

Жирс жирс гялалзан
Оддын анивчих сонихон
Жирвэс жирвэс шидлэн
Сормосны чинь хөдлөх гоёхон

Сэр сэр салхи нь
Хаая сэвэх нь учиртай
Сэм сэм амьсгаа чинь
Хацар илбэх нь урамтай

1956 он.

Чи минь л дэргэд байхгүй бол
Би, шөнийн тэнгэр саргүйтэй адил
Чи минь л дэргэд байх юм бол
Би, шүүдэр гялалзсан цэцэгтэй ижил

1957 он.

## ТУУЛЫН УРСГАЛ ШӨНӨДӨӨ САЙХАН

Туулын урсгал шөнөдөө сайхан сан
Торгон долгио хаялан мяралздагсан
Хоёр ангир дандаа л хөвдөг сөн
Холын анир авангаа л дуугардаг сан.

Урсгалд нь умбагч сарыг ажин
Усанд нь хөвөгч оддыг тоолон
Бүүр түүрхэн тохиолдлоо дурсан
Үүр цайлгах би дуртай сан.

Шившин шивнэх залуу навчис
Шөнийн дуу над аялдагсан
Сөөг моддын нь нэгийг түшин
Шөнөжин сууж би сонсдог сон.

1957 он.

## Талд Унасан жавар

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Талд унасан жавар
Ташуур алдам хайравч
Холд хөхөрсөн хөндий
Хоногийн газар цэлийвч

Зул шиг ассан хайр минь
Сум шиг чам руу хөтлөн
Аргалын халуу дүүгсэн
Аавын гэрээс гаргадаг сан.

Уулаас яарсан сэтгэл минь
Гэрийн чинь үүдэнд оччихоод
Туйлаас хаядсан хөндийд
Хээрийн шөнө давхихад

Хүлгийн дөрвөн туурайнд
Хунгарын ширхэг шажигнан
Хүүрэн манарсан тэнгэрт
Мөнгөн сар мэлмэрдэгсэн.

1959 он.

## БАДАМЛЯНХУАН ЦЭЦЭГ

Бадамлянхуа гоолиг цэцэг
Бахдам сайхан ургадаг гэнэм
Аглаг хээр нутагт минь ургадаггүй ч
Ардын дуунд магтан дуулнам

Амрагийг хайрлах хайрын сэтгэл
Аяндаа тэгж сэтгэлд үүснэ.
Халуун янагт дурлаагүй ч гэсэн
Залуу хүний сэтгэл гэгэлзэнэ.

1957 он

## ГЭР

Хаяа нь дэрвэсэн цагаан гэрийг
Харуулдаж суугаа миний нүдэнд

Аянч хун жигүүрээ дэлгэн

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

Алс нисэх гэж байх шиг харагдлаа.

Айснаас болж дотор минь палхийж
Андуурсанаа мэдээд сэтгэлээ барилаа.

Янаг хүүхний минь суудаг гэр
Яг л нисчих гээд байх шиг зовоох юм.

1956 он.

Нүд булаам сайхан өүсгүйг олж хараад
Нэгч үг солилгүй олны хөлд алдах нь
Сайхан санаа сэтгэлд гэнэт сэрхийн ороод
Шүлгийн бадагт үлдээгүйгээс юуны өөр.

1956

Нарны илч шиг төөнөөд ирэхдээ дурлал
Гантиг ханыг ч бол нэвтлээд орно.
Нүүдлийн шувуу шиг буцаад явахдаа дурлал
Ган аргамжаас ч бол мултраад арилна.

1956

Нүдэнд дулаан борхон бүсгүйн сормосонд
Нулимсны тунгалаг дусал бөнжигнөнө.
Өглөөний шүүдэр шиг ариухан тэр дусалд
Өргөн цэнхэр далай долгилохыг би үзнэм.

Оюу хөх мандалд нь өнчин завиар
Омог хархүү дур мэдэн зоргоор сэлнэ.
Дусал – Далай хүүхний сормосноос заавал тасарна
Дурааараа дургисан хархүү тэгээд хоосон хоцорно.

1958

Цэцгэн дээр байсан эрвээхэй
Гал руу нисээд орчихдог юм.
Цээжинд байгаа зүрхэнд
Гэв гэнэтхэн суучихдаг юм.

Үйлээ эдлэх эрвээхэйг
Үүдээр хөөгөөд гаргадаггүй юм.
Үүрд шархлуулсан тэр хүнийг
Өшрөн мартах гээд чаддаггүй юм.

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

1957 он.
Переделкино тосгон

## ШӨНИЙН ТАНГО

Цэвдэг хүйтэн шөнийн харанхуйд
Чинийхээ төлөө би дуулна
Оюун сэтгэлдээ чамайг бодоостой
Оддын доор үүрийг хүлээнэ.

Халуу дүүгсэн зөөлөн хөнжилдөө
Хайрт чи минь зүүдлэнхэн нойрсоно.
Өнөр цэнгэл бялхсан өргөөнд
Өөр хүнтэй зугаалан зүүдэлнэ.

Шөнийн ододтой нөхөрлөн суухад
Сайхан дүр чинь дэргэд ирнэ.
Ухаангүй дурлалын нууц чадлаар
Ужиг шөнийн уртыг туулна.

Цэвдэг хүйтэн шөнийн харанхуйд
Цонхны чинь барааг ширтэн сууна.
Залуу насны минь бэлэг болсон
Шөнийн тангог чамдаа дуулна.

1960 он.

## ЧИНИЙ ДУРЛАЛ

Хавирган сар нэмэн нэмсээр дүүрдэг шиг
Хайрын сэтгэл минь улам чамд дасаад байх юм.

Сарны гэрэлд лянхуа навчсаа хумьдаг шиг
Сайхан чиний хайрын илч чинь буураад байх юм.

Өвсөнд буусан үүрийн шүүдэр хийсдэг шиг
Арилах болов уу,

Усанд унасан борооны дусал хатдаггүй шиг
Амьдрах болов уу?
Чиний дурлал.

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com

1958 он.

Жавхаалаг нар огторгуйд мандан гарахлаар
Жаварлаг оддын гэрэл сүлэгдэн уусна.
Түүний адил, онцгой нэгэн дурлалын өмнө
Түрүүчийн бүх шалиглал хайлан замхарна.

1958 он.

## ЦЭНХЭР НОМИН ОГТОРГУЙ

Цэнхэр номин огторгуй
Анхны дурлал шиг хиргүй
Цэнхэр номин огторгуй
Анхны дурлал шиг биегүй
Аяа, Цэнхэр номин огторгуй.

1965 он

Дурлал гэдэг амны хий биш
Дуртай болгон зайдалдаг хонины морь биш,
Хорвоод хүн ганцхан л удаа төрдөг юм.
Хосгүй амрагаа гэж нэг л хүнийг шилдэг юм.

1961 он.

PDF Created with deskPDF PDF Writer - Trial :: http://www.docudesk.com